



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДАГЫН АЛБА

# ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2021 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

/Албан хэрэгцээнд/

Улаанбаатар хот  
2022 он

Бэлтгэсэн: Статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн ахмад С.Энхбаатар  
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Нансал  
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Э.Батгэрэл  
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ч.Баатарсүрэн  
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Гэрэлцэцэг  
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Амаржаргал  
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Уянга  
Мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Хулангоо

Хянасан: Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга,  
цагдаагийн хурандаа Ж.Буянбат  
Статистик, мэдээллийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж

Формат: А4/210\*297/

Хэвлэлийн 28.5хх

хуудас:

Хэвлэсэн тоо: 200 ширхэг

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.

## ГАРЧИГ

ГАРЧИГ .....

НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ .....

ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ .....

ГУРАВ. ОРОН НУТАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ .....

ДӨРӨВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ .....

4.1 Хүнийг алах гэмт хэрэг .....

4.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг .....

4.3 Хүчиндэх гэмт хэрэг .....

4.4 Хулгайлах гэмт хэрэг .....

4.5 Хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг .....

4.6 Халаасны хулгайн гэмт хэрэг .....

4.7 Мал хулгайлах гэмт хэрэг .....

4.8 Дээрэмдэх гэмт хэрэг .....

4.9 Залилах гэмт хэрэг .....

4.10 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг .....

4.11 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг .....

4.12 Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг .....

4.13 Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг .....

4.14 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг .....

ТАВ. ГЭМТ ХЭРГИЙН ОНЦЛОГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ .....

5.1 Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг .....

5.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил .....

5.3 Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг .....

5.4 Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг .....

5.5 Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг .....

ЗУРГАА. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ .....

6.1 Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг .....

6.2 Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг .....

6.3 Гадаадын иргэнээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил .....

ДОЛОО. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2021 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛИЙН  
НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ .....

НАЙМ. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛИЙН НЭГДСЭН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ .....

# НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Цагдаагийн байгууллага нь 2021 онд хүн, хуулийн этгээдээс 267.221 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 71.495 буюу 26.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 195.726 буюу 73.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 6864 буюу 2.6, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 3948 буюу 5.8, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 2916 буюу 1.5 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 23139 буюу 32.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 44165 буюу 61.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 752 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 134.146 буюу 68.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 58.601 буюу 29.9 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 1183 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

### 1.2 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 25.429 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 16.534 буюу 65.0 хувь нь Улаанбаатар хотод, 8880 буюу 34.9 хувь нь орон нутагт, 15 буюу 0.1 хувь нь бусад газар /хилийн чанадад үйлдэгдсэн/ бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 2365 хэрэг буюу 10.3 хувиар, нийслэлийн хэмжээнд 1901 хэрэг буюу 13.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 460 хэрэг буюу 5.5 хувиар, бусад газар /хилийн чанадад/-т 4 хэрэг буюу 36.4 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сүүлийн 10 жилээр:



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 27819, сард 2318, хоногт 77, цагт 3 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.




Гэмт хэрэг 9 аймаг, 2 дүүрэгт 1.1 хувиас 39.3 хувиар буурч, 12 аймаг, 7 дүүрэгт 1.7 хувиас 54.1 хувиар өссөн байна.

Д/д	Нэгж	2020 он	2021 он	Өсөлт, бууралт		Д/д	Нэгж	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Архангай	435	412	-23	-5.3	17	Төв	737	611	-126	-17.1
2	Баян-Өлгий	308	187	-121	-39.3	18	Увс	188	239	51	27.1
3	Баянхонгор	462	428	-34	-7.4	19	Ховд	394	416	22	5.6
4	Булган	349	388	39	11.2	20	Хөвсгөл	535	716	181	33.8
5	Говь-Алтай	151	231	80	53.0	21	Хэнтий	531	540	9	1.7
6	Говьсүмбэр	148	135	-13	-8.8	<b>Нийслэлд</b>					
7	Дархан-Уул	566	543	-23	-4.1	22	Баянгол	2257	2758	501	22.2
8	Дорноговь	318	490	172	54.1	23	Баянзүрх	4083	4217	134	3.3
9	Дорнод	476	536	60	12.6	24	Сүхбаатар	2023	2285	262	13.0
10	Дундговь	196	245	49	25.0	25	Сонгинохайрхан	2337	2903	566	24.2
11	Завхан	271	367	96	35.4	26	Хан-Уул	1650	2045	395	23.9
12	Орхон	533	504	-29	-5.4	27	Чингэлтэй	1775	1864	89	5.0
13	Өвөрхангай	407	458	51	12.5	28	Багануур	143	163	20	14.0
14	Өмнөговь	458	453	-5	-1.1	29	Багахангай	26	20	-6	-23.1
15	Сүхбаатар	408	344	-64	-15.7	30	Налайх	339	279	-60	-17.7
16	Сэлэнгэ	549	637	88	16.0	31	Бусад	11	15	4	36.4

#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 22091 буюу 86.9 хувь нь хөнгөн, 3338 буюу 13.1 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 14.8 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 12.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>1</sup>



#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	382	448	17.3	1.8
	Үүнээс: Хүнийг алах	192	194	1.0	0.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7405	7637	3.1	30.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	111	118	6.3	0.5
3	Хүний бэлгийн эрх чөлөө. халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	505	540	6.9	2.1
	Үүнээс: Хүчиндэх	401	439	9.5	1.7
4	Хүний халдашгүй. чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	189	210	11.1	0.8
5	Хүний хувийн. улс төрийн эрх. эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	5	2	-60.0	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	22	28	27.3	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	17	31	82.4	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	12061	13632	13.0	53.6
8	Хулгайлах	5100	4579	-10.2	18.0
	Дээрэмдэх	404	366	-9.4	1.4
	Залилах	4270	6558	53.6	25.8
	Малын хулгай	1041	736	-29.3	2.9
9	Эдийн засгийн гэмт хэрэг	123	158	28.5	0.6
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.0

<sup>1</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

11	Олон нийтийн аюулгүй байдал. ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	291	756	2.6 дах	3.0
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	80	52	-35.0	0.2
13	Авлигын эсрэг гэмт хэрэг <sup>2</sup>	8	15	87.5	0.1
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	211	232	10.0	0.9
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	622	601	-3.4	2.4
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	5	8	60.0	0.0
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	146	151	3.4	0.6
18	Хөдөлгөөний аюулгүй байдал. тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	985	915	-7.1	3.6
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал. ашиглалтын журам зөрчих	981	912	-7.0	3.6
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	6	11	83.3	0.1
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал. энх тайвны эсрэг гэмт хэрэг				


### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 3833 буюу 15.1 хувь нь даваа гарагт, 3879 буюу 15.3 хувь нь мягмар гарагт, 3881 буюу 15.3 хувь нь лхагва гарагт, 3814 буюу 15.0 хувь нь пүрэв гарагт, 3771 буюу 14.8 хувь нь баасан гарагт, 3137 буюу 12.3 хувь нь бямба гарагт, 3114 буюу 12.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 7361 буюу 28.9 хувь нь 06:00-14:00 цагт, 7691 буюу 30.2 хувь нь 14:00-19:00 цагт, 3759 буюу 14.8 хувь нь 19:00-22:00 цагт, 6618 буюу 26.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.8 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 9940 буюу 39.1 хувь нь гэр орон сууцанд, 4757 буюу 18.7 хувь нь гудамж талбайд, 2021 буюу 7.9 хувь нь олон нийтийн газарт, 114 буюу 0.4 хувь нь нийтийн тээвэрт, 230 буюу 0.9 хувь нь төрийн байгууллагад, 160 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 1858 буюу 7.3 хувь нь аж ахуйн нэгжид, 909 буюу 3.6 хувь нь авто замд, 5440 буюу 21.5 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 4842 буюу 19.0 хувь нь согтуугаар, 3218 буюу 12.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1367 буюу 5.4 хувь нь бүлэглэн, 733 буюу 2.9 хувь нь хүүхэд оролцож, 1531 буюу 6.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн үлмаас тус тус үйлдэгдсэн байна.


<sup>2</sup> Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг “Авлигын гэмт хэрэг” -ийг харьяаллаар АТГ шалгана.



## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт хэргийн 9931 буюу 39.0 хувь нь далд аргаар үйлдэгдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 52.7 хувь, нийслэлд 50.3 хувь, орон нутагт 58.9 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 0.8, нийслэлд 2.0 нэгжээр тус тус өсч, орон нутагт 0.3 нэгжээр буурсан байна.



### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 19305 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1639 хэрэг буюу 9.3 хувиар, үүнээс 10173 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1012 буюу 11.0 хувиар тус тус өссөн.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 18078 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1411 буюу 8.5 хувиар өссөн. Холбогдогчдын 2927 буюу 16.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 20 буюу 0.7 хувиар өсч, 921 буюу 5.1 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 69 буюу 7.0 хувиар буурсан байна.

### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гадаадын 19 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 9.5 хувиар буурсан байна.


## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн үлмаас 24994 иргэн, 59 хуулийн этгээд хохирч, үүнээс 683 хүн нас барж, 8299 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 1944 буюу 8.4 хувиар, нас барсан хүн 13 буюу 1.9 хувиар, гэмтсэн хүн 124 буюу 1.5 хувиар тус тус өссөн байна.



### 4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 180339.4 сая төгрөгийн хохирлын 90376.7 сая төгрөг буюу 50.1 хувийг нөхөн төлүүлж, 6541.2 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 74598.3 сая төгрөг буюу 29.3 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 8297.3 сая төгрөг буюу 10.1 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 119.8 сая төгрөг буюу 1.9 хувиар тус тус өссөн байна.

## Тав. Зөрчил

### 5.1 Нийт бүртгэгдсэн зөрчил.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 2.074.412 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 202.456 буюу 8.9 хувиар, үүнээс 2.069.950 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 202.396 буюу 8.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



Нийт бүртгэгдсэн зөрчлийн 1.866.153 буюу 90.0 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 78.725 буюу 3.8 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 9526 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3947 буюу 0.2 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 116.061 буюу 5.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 1.960.507 иргэн, 60.708 хуулийн этгээдийг 75.0 тэрбум төгрөгөөр торгох, 15.277 хүнийг шүүхээр баривчлуулах, 33.458 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс торгуулсан иргэн 187.724 буюу 8.7 хувиар, хуулийн этгээд 24.925 буюу 29.1 хувиар, баривчлуулсан шийтгэл 1614 буюу 9.6 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 11.867 буюу 55.0 хувиар өссөн байна.

### 5.2 Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа.

Улсын хэмжээнд 2021 онд нийт 70.479 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.384 буюу 24.9 хувиар буурчээ. Эрүүлжүүлэгдсэн хүний 55.002 буюу 78.0 хувь нь Улаанбаатар хотод, 15.477 буюу 22.0 хувь нь орон нутагт эрүүлжүүлэгдсэн байна. Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 63.967 буюу 90.7 хувь нь эрэгтэй, 6512 буюу 9.3 хувь нь эмэгтэй, 193 буюу 0.3 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Архины албадан эмчилгээнд 353 хүн, сайн дурын эмчилгээнд 331 хүнийг хамруулсан байна.



# ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

## Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн хэмжээнд 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 185.411 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 48.793 буюу 26.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 136.618 буюу 73.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 25.471 буюу 15.9, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 2459 буюу 5.3, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 23.012 буюу 20.3 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 13.087 буюу 26.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 32.803 буюу 67.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 367 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 88.257 буюу 64.6 хувийг зөрчлийн хэрэг нээж, 46.986 буюу 34.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 143 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 16.534 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1901 буюу 13.0 хувиар өсч, улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 65.0 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 18.035, сард 1503, хоногт 50, цагт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сүүлийн 10 жилээр:




### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.



#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 14.763 буюу 89.3 хувь нь хөнгөн, 1771 буюу 10.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 17.4 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 14.1 хувиар буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>3</sup>



#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	208	272	30.8	1.6
	Үүнээс: Хүнийг алах	95	109	14.7	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4564	4551	-0.3	27.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	65	49	-24.6	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	255	269	5.5	1.6
	Үүнээс: Хүчиндэх	203	225	10.8	1.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	130	139	6.9	0.8
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1			
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	16	20	25.0	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	13	27	2.0 дах	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	8355	9785	17.1	59.2
8	Үүнээс: Хулгайлах	3481	3283	-5.7	19.9
	Дээрэмдэх	341	305	-10.6	1.8
	Залилах	3621	5240	44.7	31.7
	Мал хулгайлах	63	42	-33.3	0.3
9	Эдийн засгийн гэмт хэрэг	70	130	85.7	0.8
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		2		0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	237	534	2.2 дах	3.2
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	50	34	-32.0	0.2
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	124	136	9.7	0.8
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	52	52	0.0	0.3
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	119	133	11.8	0.8
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	431	443	2.8	2.7
18	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	430	442	2.8	2.7
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.0

#### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 2577 буюу 15.6 хувь нь даваа гарагт, 2537 буюу 15.3 хувь нь мягмар гарагт, 2538 буюу 15.4 хувь нь лхагва гарагт, 2444 буюу 14.8 хувь нь пүрэв гарагт, 2486 буюу 15.0 хувь нь баасан гарагт, 2011 буюу 12.2 хувь нь бямба гарагт, 1941 буюу 11.7 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 5390 буюу 32.6 хувь нь 06:00-14:00 цагт, 4999 буюу 30.2 хувь нь 14:00-22:00 цагт, 4474 буюу 27.6 хувь нь 22:00-06:00 цагт бүртгэгдсэн байна.


<sup>3</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

нь 14:00-19:00 цагт, 2223 буюу 13.4 хувь нь 19:00-22:00 цагт, 3922 буюу 23.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл нийт гэмт хэргийн 6557 буюу 39.7 хувь нь гэр орон сууцанд, 3796 буюу 23.0 хувь нь гудамж талбайд, 1632 буюу 9.9 хувь нь олон нийтийн газарт, 104 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 110 буюу 0.7 хувь нь төрийн байгууллагад, 122 буюу 0.7 хувь нь төрийн бүс байгууллагад, 1570 буюу 9.5 хувь нь аж ахуйн нэгжид, 460 буюу 2.8 хувь нь авто замд, 2183 буюу 13.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 2118 буюу 12.8 хувь нь согтуугаар, 2443 буюу 14.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 765 буюу 4.6 хувь нь бүлэглэн, 490 буюу 3.0 хувь нь хүүхэд оролцож, 852 буюу 5.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.


Д/д	Дүүрэг	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баянгол	181	49	461	86	161	
2	Баянзүрх	684	147	692	199	166	2
3	Сүхбаатар	152	68	337	88	144	1
4	Сонгинохайрхан	360	71	298	215	87	
5	Хан-Уул	255	109	251	118	128	
6	Чингэлтэй	275	36	342	87	71	1
7	Багануур	84	1	22	16	4	
8	Багахангай	10	1	2	3		
9	Налайх	117	8	38	40	4	
<b>Нийт</b>		<b>2118</b>	<b>490</b>	<b>2443</b>	<b>852</b>	<b>765</b>	<b>4</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн хэргийн 6275 буюу 38.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 50.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр өссөн.

Улсын гэмт хэргийн илрүүлэлттэй харьцуулахад 3.4 нэгжээр бага байна.



## 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 13763 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1885 хэрэг буюу 41.6 хувиар, үүнээс 6917 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1184 буюу 20.7 хувиар тус тус өссөн байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 10568 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1180 буюу 12.6 хувиар өссөн. Холбогдогчдын 2160 буюу 20.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.2 хувиар, 594 буюу 5.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 9.2 хувиар тус тус буурч, 8408 буюу 79.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 16.4 хувиар өссөн байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 16060 иргэн, 32 хуулийн этгээд хохирч, үүнээс 339 хүн нас барж, 4677 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 1596 буюу 11.0, нас барсан хүн 55 буюу 19.4, хохирсон хуулийн этгээд 11 буюу 52.4 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 81 буюу 1.7 хувиар буурсан байна.



### 4.2 Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 149283.9 сая төгрөгийн хохирлын 49.6 хувийг нөхөн төлүүлж, 3526.9 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 72974.0 сая буюу 32.8 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 6801.2 буюу 10.1, битүүмжилсэн хөрөнгө 589.4 сая буюу 20.1 хувиар тус тус өссөн байна.

### Тав. Зөрчил

Нийслэлийн хэмжээнд нийт 1.602.613 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 150.437 буюу 8.6 хувиар, 1.599.825 зөрчлийг шийдвэрлэсэн нь 149.999 буюу 8.6 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 1.445.584 буюу 90.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 69.407 буюу 4.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 6275 буюу 0.4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3729 буюу 0.2 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 77.618 буюу 4.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 1.515.003 иргэн, 60.553 хуулийн этгээдийг 52918833.3 мянган төгрөгөөр торгох, 7234 хүнийг баривчлуулах, 17035 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс торгуулсан иргэн 8.0 хувиар, баривчлуулсан шийтгэл 1166 буюу 13.9 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 7184 буюу 72.9 хувиар өссөн байна.

2021 онд Нийслэлийн хэмжээнд нийт 55.002 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14726 буюу 21.1 хувиар буурсан байна.

---oooOooo---

## 2.1 БАЯНГОЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Баянгол дүүрэг дэх цагдаагийн газар нь 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 29248 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 8654 буюу 29.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 20594 буюу 70.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 4245 буюу 17.0, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 4439 буюу 27.5 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 194 буюу 2.2 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 1786 буюу 20.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 6276 буюу 72.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 67 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 14164 буюу 68.8 хувийг зөрчлийн хэрэг нээж, 6216 буюу 30.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 33 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 2758 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 501 буюу 22.2 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 16.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 2931, сард 244, хоногт 8 хэрэг үйлдэгдсэн байна.

Тус дүүрэгт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



#### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.




Д/д	Хороо	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	1-р хороо	117	90	-27	-23.1
2	2-р хороо	180	212	32	17.8
3	3-р хороо	144	233	89	61.8
4	4-р хороо	123	133	10	8.1
5	5-р хороо	100	157	57	57.0
6	6-р хороо	303	141	-162	-53.5
7	7-р хороо	96	168	72	75.0
8	8-р хороо	81	117	36	44.4
9	9-р хороо	69	46	-23	-33.3
10	10-р хороо	30	42	12	40.0
11	11-р хороо	62	95	33	53.2
12	12-р хороо	59	73	14	23.7
13	13-р хороо	77	137	60	77.9
14	14-р хороо	63	69	6	9.5
15	15-р хороо	42	49	7	16.7
16	16-р хороо	82	95	13	15.9
17	17-р хороо	160	131	-29	-18.1
18	18-р хороо	109	92	-17	-15.6
19	19-р хороо	50	49	-1	-2.0
20	20-р хороо	191	386	195	2.0 дах
21	21-р хороо	28	50	22	78.6
22	22-р хороо	58	57	-1	-1.7
23	23-р хороо	19	29	10	52.6
24	24-р хороо	9	48	39	5.3 дах
25	25-р хороо	5	59	54	11.8 дах

#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 2608 буюу 94.6 хувь нь хөнгөн, 150 буюу 5.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн хэрэг 22.8, хүнд хэрэг 11.9 хувиар тус тус өссөн байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>4</sup>




#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	30	29	-3.3	1.1
	Үүнээс: Хүнийг алах	13	9	-30.8	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	636	546	-14.2	19.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	5	0.0	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	31	28	-9.7	1.0
	Үүнээс: Хүчиндэх	23	23	0.0	0.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	12	8	-33.3	0.3
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.1
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дах	0.1
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1392	1937	39.2	70.2
	Үүнээс: Хулгайлах	327	479	46.5	17.4
	Дээрэмдэх	68	65	-4.4	2.4
8	Залилах	871	1238	42.1	44.9
	Эдийн засгийн гэмт хэрэг	11	15	36.4	0.5
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	43	90	2.1 дах	3.3
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	7	16.7	0.3
11	Авлигын эсрэг гэмт хэрэг				0.0
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	22	17	-22.7	0.6
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	6	1	-83.3	0.0
14	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг				0.0
15	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	20	53.8	0.7
16	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	49	52	6.1	1.9
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	49	52	6.1	1.9

#### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 463 буюу 16.8 хувь нь даваа гарагт, 460 буюу 16.7 хувь нь мягмар гарагт, 392 буюу 14.2 хувь нь лхагва гарагт, 382 буюу 13.9 хувь нь пүрэв гарагт, 410 буюу 14.9 хувь нь баасан гарагт, 320 буюу 11.6 хувь нь бямба гарагт, 331 буюу 12.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 835 буюу 30.3 хувь нь 06:00-14:00 цагт, 903 буюу 32.7 хувь нь 14:00-19:00 цагт, 333 буюу 12.1 хувь нь 19:00-22:00 цагт, 687 буюу 24.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

<sup>4</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1113 буюу 40.4 хувь нь гэр орон сууцанд, 699 буюу 25.3 хувь нь гудамж талбайд, 435 буюу 15.8 хувь нь олон нийтийн газарт, 9 буюу 0.3 хувь нь нийтийн тээвэрт, 17 буюу 0.6 хувь нь төрийн байгууллагад, 32 буюу 1.2 хувь нь төрийн бус байгууллагад, 351 буюу 12.7 хувь нь аж ахуйн нэгжид, 54 буюу 2.0 хувь нь авто замд, 48 буюу 1.7 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 181 буюу 6.6 хувь нь согтуугаар, 461 буюу 16.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 161 буюу 5.8 хувь нь бүлэглэн, 49 буюу 1.8 хувь нь хүүхэд оролцож, 86 буюу 3.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Хороо	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн
1	1-р хороо	5	3	26	3	11
2	2-р хороо	20	4	63	5	23
3	3-р хороо	17	5	102	7	22
4	4-р хороо	9	5	10	4	5
5	5-р хороо	4	6	11	2	3
6	6-р хороо	4	2	17	6	2
7	7-р хороо	8	2	9	6	6
8	8-р хороо	6	1	9		1
9	9-р хороо	3	2	5	5	3
10	10-р хороо	2	1	3	5	2
11	11-р хороо	8	3	19	3	5
12	12-р хороо	11	1	18	2	10
13	13-р хороо	4	4	13		5
14	14-р хороо	2	1	18	1	9
15	15-р хороо	4	1	16	1	3
16	16-р хороо	18	1	14	4	5
17	17-р хороо	13		19	6	14
18	18-р хороо	8	3	14	9	7
19	19-р хороо	4		12		6
20	20-р хороо	5		23	5	6
21	21-р хороо	8	2	4	1	2
22	22-р хороо	11		9	4	3
23	23-р хороо	1		9	2	4
24	24-р хороо	4		13	2	3
25	25-р хороо	2	2	5	3	1
	<b>Нийт</b>	<b>181</b>	<b>49</b>	<b>461</b>	<b>86</b>	<b>161</b>




## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянгол дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 717 буюу 26.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 57.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.9 нэгжээр буурсан.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 6.7 нэгжээр их байна.



### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 2382 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 297 хэрэг буюу 14.2 хувиар, 1358 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 88 буюу 6.9 хувиар тус тус өссөн байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 1881 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.0 хувиар өссөн. Холбогдогчдын 1409 буюу 74.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.9 хувиар, 472 буюу 25.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 22.3 хувиар тус тус өсч, 56 буюу 3.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 41.1 хувиар буурсан байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 2668 иргэн, 8 хуулийн этгээд хохирч, 35 хүн нас барж, 604 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 449 буюу 20.2 хувиар өсч, нас барсан хүн 5 буюу 12.5 хувиар, гэмтсэн хүн 96 буюу 13.7 хувиар тус тус буурсан.



### 4.2 Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 19447.4 сая төгрөгийн хохирлын 35.9 хувийг нөхөн төлүүлж, 1796.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 3857.4 сая төгрөг буюу 24.7 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 1027.2 сая буюу 2.3 дахин өсч, нөхөн төлүүлсэн хохирол 52.4 сая төгрөг буюу 0.7 хувиар буурсан байна.

## Тав. Зөрчил

Нийслэлийн Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын хэмжээнд нийт 106.099 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 78.428 буюу 3.8 дахин, 105.736 зөрчлийг шийдвэрлэсэн нь 78397 буюу 3.9 дахин тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 77583 буюу 73.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 17400 буюу 16.4 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 898 буюу 0.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 900 буюу 0.8 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 9318 буюу 8.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 101.635 иргэн, 797 хуулийн этгээдийг 4292210.0 мянган төгрөгөөр торгох, 867 хүнийг баривчлуулсан нь өмнөх оны мөн үеэс торгосон иргэн 75226 буюу 3.8 дахин, хуулийн этгээд 574 буюу 3.6 дахин, баривчлуулсан шийтгэл 160 буюу 22.6 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 2437 бүртгэгдсэн байна.

2021 онд Нийслэлийн Баянгол дүүрэгт нийт 5887 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2978 буюу 33.6 хувиар буурсан байна.

---oooOooo---

## 2.2 БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 47088 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 12607 буюу 26.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 34481 буюу 73.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 2272 буюу 5.1, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 1064 буюу 9.2, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 1208 буюу 3.6 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 3420 буюу 27.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 8456 буюу 67.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 102 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 19703 буюу 57.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 14520 буюу 42.1 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 13 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 4217 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 134 буюу 3.3 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 25.5 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 4646, сард 387, хоногт 13 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус дүүрэгт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



#### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.




Д/д	Хороо	2020 он	2021 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	122	173	51	41.8	15	15-р хороо	98	107	9	9.2
2	2-р хороо	216	343	127	58.8	16	16-р хороо	171	149	-22	-12.9
3	3-р хороо	84	123	39	46.4	17	17-р хороо	91	57	-34	-37.4
4	4-р хороо	207	271	64	30.9	18	18-р хороо	244	119	-125	-51.2
5	5-р хороо	238	227	-11	-4.6	19	19-р хороо	77	88	11	14.3
6	6-р хороо	135	171	36	26.7	20	20-р хороо	89	109	20	22.5
7	7-р хороо	173	132	-41	-23.7	21	21-р хороо	140	123	-17	-12.1
8	8-р хороо	302	256	-46	-15.2	22	22-р хороо	139	139	0	0.0
9	9-р хороо	93	115	22	23.7	23	23-р хороо	83	116	33	39.8
10	10-р хороо	74	109	35	47.3	24	24-р хороо	45	47	2	4.4
11	11-р хороо	166	136	-30	-18.1	25	25-р хороо	111	129	18	16.2
12	12-р хороо	112	117	5	4.5	26	26-р хороо	215	185	-30	-14.0
13	13-р хороо	87	100	13	14.9	27	27-р хороо	126	122	-4	-3.2
14	14-р хороо	407	349	-58	-14.3	28	28-р хороо	38	105	-67	2.8 дах

#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3737 буюу 88.6 хувь нь хөнгөн, 480 буюу 11.4 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 5.6 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 11.6 хувиар буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>5</sup>




#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	54	95	75.9	2.3
	Үүнээс: Хүнийг алах	27	27	0.0	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1339	1221	-8.8	29.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	6	8	33.3	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	77	77	0.0	1.8
	Үүнээс: Хүчиндэх	58	68	17.2	1.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	23	33	43.5	0.8
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	7	7	0.0	0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	8	2.0 дах	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2360	2408	2.0	57.1
	Хулгайлах	1014	840	-17.2	19.9
7	Дээрэмдэх	93	77	-17.2	1.8
	Залилах	1060	1286	21.3	30.5
	Мал хулгайлах	10	7	-30.0	0.2
8	Эдийн засгийн гэмт хэрэг	16	28	75.0	0.7
9	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	51	166	3.3 дах	3.9
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	11	83.3	0.3
12	Авлигын эсрэг гэмт хэрэг				
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	22	37	68.2	0.9
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	11	17	54.5	0.4
15	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	11	-35.3	0.3
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	95	96	1.1	2.3
16	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	94	95	1.1	2.3
17	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.02

<sup>5</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.


### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 604 буюу 14.3 хувь нь даваа гарагт, 610 буюу 14.5 хувь нь мягмар гарагт, 665 буюу 15.8 хувь нь лхагва гарагт, 629 буюу 14.9 хувь нь пүрэв гарагт, 618 буюу 14.7 хувь нь баасан гарагт, 557 буюу 13.2 хувь нь бямба гарагт, 534 буюу 12.7 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1381 буюу 32.7 хувь нь 06:00-14:00 цагт, 1180 буюу 28.0 хувь нь 14:00-19:00 цагт, 630 буюу 14.9 хувь нь 19:00-22:00 цагт, 1026 буюу 24.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1647 буюу 39.1 хувь нь гэр орон сууцанд, 1018 буюу 24.1 хувь нь гудамж талбайд, 396 буюу 9.4 хувь нь олон нийтийн газарт, 24 буюу 0.6 хувь нь нийтийн тээвэрт, 30 буюу 0.7 хувь нь төрийн байгууллагад, 28 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 237 буюу 5.6 хувь нь аж ахуйн нэгжид, 98 буюу 2.3 хувь нь авто замд, 739 буюу 17.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 684 буюу 16.2 хувь нь согтуугаар, 692 буюу 16.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 166 буюу 3.9 хувь нь бүлэглэн, 147 буюу 3.5 хувь нь хүүхэд оролцож, 199 буюу 4.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Хороо	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	1-р хороо	13	3	28	1	6	
2	2-р хороо	30	57	57	6	7	
3	3-р хороо	15	2	43		7	
4	4-р хороо	42	4	87	3	5	
5	5-р хороо	53	6	32	18	9	
6	6-р хороо	15	5	22	1	14	
7	7-р хороо	13	1	20	2	4	
8	8-р хороо	45	10	38	13	11	
9	9-р хороо	26	4	17	12	4	1
10	10-р хороо	15	2	7	7	6	
11	11-р хороо	27		13	7	4	1
12	12-р хороо	30	3	22	9	8	
13	13-р хороо	22	1	21	5	2	
14	14-р хороо	54	5	57	16	17	
15	15-р хороо	2		24		3	
16	16-р хороо	23		29	7	4	
17	17-р хороо	17	3	5	3	1	


18	18-р хороо	11	4	19	3	10	
19	19-р хороо	19	5	11	7	5	
20	20-р хороо	34	5	13	8	7	
21	21-р хороо	26	2	19	2	7	
22	22-р хороо	37	4	18	13	4	
23	23-р хороо	22	2	19	13	2	
24	24-р хороо	9	1	3		3	
25	25-р хороо	19	5	18	10	4	
26	26-р хороо	28	9	17	19	5	
27	27-р хороо	24	4	13	9	5	
28	28-р хороо	13		20	5	2	
<b>Нийт</b>		<b>684</b>	<b>147</b>	<b>692</b>	<b>199</b>	<b>166</b>	<b>2</b>

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1604 буюу 38.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 46.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгжээр буурсан.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 4.2 нэгжээр бага байна.



### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 3485 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 468 хэрэг буюу 15.5 хувиар, үүнээс 1606 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 208 буюу 14.9 хувиар тус тус өссөн байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2507 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.0 хувиар буурсан.

Холбогдогчдын 557 буюу 22.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 28.7 хувиар, 175 буюу 7.0 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 10.7 хувиар тус тус буурч, 1950 буюу 77.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 1.8 хувиар өссөн байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4041 иргэн, 5 хуулийн этгээд хохирч, үүнээс 101 хүн нас барж, 1247 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 28 буюу 0.7, гэмтсэн хүн 149 буюу 10.7 хувиар тус тус буурч, нас барсан хүн 24 буюу 31.2 хувиар өссөн байна.



### 4.2 Учирсан хохирол.




Иргэдэд учирсан 24936.5 сая төгрөгийн хохирлын 41.8 хувийг нөхөн төлүүлж, 957.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 1462.8 сая буюу 6.2, нөхөн төлүүлсэн хохирол 2591.2 сая буюу 33.0 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 953.2 сая буюу 251.8 дахин тус тус өссөн байна.

### Тав. Зөрчил

Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын хэмжээнд нийт 160.200 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 134.827 буюу 6.3 дахин, 159.554 зөрчлийг шийдвэрлэсэн нь 134.793 буюу 6.5 дахин тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 134.018 буюу 83.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 8123 буюу 5.1 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 1994 буюу 1.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 588 буюу 0.4 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 15477 буюу 9.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 151.585 иргэн, 2005 хуулийн этгээдийг 6810500.6 мянган төгрөгөөр торгож, 2091 хүнийг баривчлуулсан нь өмнөх оны мөн үеэс баривчлуулах шийтгэл 31 буюу 1.5 хувиар, торгосон хүн 129.035 буюу 6.7 дахин, торгосон хуулийн этгээд 1854 буюу 13.3 дахин тус тус өссөн байна.

2021 онд Нийслэлийн Баянзүрх дүүрэгт нийт 7416 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3252 буюу 30.5 хувиар буурсан байна.

---oooOooo---

## 2.3 СҮХБААТАР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 23917 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 6547 буюу 27.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 17370 буюу 72.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 5520 буюу 30.0, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 552 буюу 9.2, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 4968 буюу 40.1 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 1297 буюу 19.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 4821 буюу 73.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 32 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 12111 буюу 69.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 5059 буюу 29.1 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 23 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 2285 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 262 буюу 13.0 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 13.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 2870, сард 239, хоногт 8 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус дүүрэгт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



#### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	1-р хороо	374	590	216	57.8
2	2-р хороо	35	35	0	0.0
3	3-р хороо	135	112	-23	-17.0
4	4-р хороо	115	93	-22	-19.1
5	5-р хороо	50	43	-7	-14.0
6	6-р хороо	148	130	-18	-12.2
7	7-р хороо	77	124	47	61.0
8	8-р хороо	237	247	10	4.2
9	9-р хороо	110	139	29	26.4
10	10-р хороо	90	105	15	16.7
11	11-р хороо	156	184	28	17.9
12	12-р хороо	62	75	13	21.0
13	13-р хороо	56	81	25	44.6
14	14-р хороо	49	45	-4	-8.2
15	15-р хороо	45	33	-12	-26.7
16	16-р хороо	84	66	-18	-21.4
17	17-р хороо	25	28	3	12.0
18	18-р хороо	52	45	-7	-13.5
19	19-р хороо	70	51	-19	-27.1
20	20-р хороо	53	59	6	11.3






#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 2058 буюу 90.1 хувь нь хөнгөн, 227 буюу 9.9 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 16.7 хувь өсч, хүнд гэмт хэрэг 12.4 хувиар буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>6</sup>



#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	16	25	56.3	1.1
	Үүнээс: Хүнийг алах	5	11	2.2 дах	0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	540	526	-2.6	23.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	25	5	-80.0	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	26	37	42.3	1.6
	Үүнээс: Хүчиндэх	21	29	38.1	1.3
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	29	44	51.7	1.9
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг				
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	2	5	2.5 дах	0.2
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		4		0.2
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1202	1428	18.8	62.5
	Хулгайлах	463	440	-5.0	19.3
	Дээрэмдэх	55	26	-52.7	1.1
	Залилах	548	836	52.6	36.6
	Мал хулгайлах				
9	Эдийн засгийн гэмт хэрэг	10	19	90.0	0.8
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	38	63	65.8	2.8
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	16	10	-37.5	0.4
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	1	1		0.04
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	33	35	6.1	1.5
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	6	4	-33.3	.2
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		2		0.1
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	40	31	-22.5	1.4
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	64	50	-21.9	2.2
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	64	50	-21.9	2.2

#### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 357 буюу 15.6 хувь нь даваа гарагт, 331 буюу 14.5 хувь нь мягмар гарагт, 400 буюу 17.5 хувь нь лхагва гарагт, 354 буюу 15.5 хувь нь пүрэв гарагт, 337 буюу


<sup>6</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

14.7 хувь нь баасан гарагт, 270 буюу 11.8 хувь нь бямба гарагт, 236 буюу 10.4 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 926 буюу 40.5 хувь нь 06:00-14:00 цагт, 629 буюу 27.5 хувь нь 14:00-19:00 цагт, 202 буюу 8.8 хувь нь 19:00-22:00 цагт, 528 буюу 23.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 657 буюу 28.8 хувь нь гэр орон сууцанд, 520 буюу 22.8 хувь нь гудамж талбайд, 279 буюу 12.2 хувь нь олон нийтийн газарт, 12 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 22 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 20 буюу 0.9 хувь нь төрийн бус байгууллагад, 378 буюу 16.5 хувь нь аж ахуйн нэгжид, 53 буюу 2.3 хувь нь авто замд, 344 буюу 15.0 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 152 буюу 6.7 хувь нь согтуугаар, 337 буюу 14.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 144 буюу 6.3 хувь нь бүлэглэн, 68 буюу 3.0 хувь нь хүүхэд оролцож, 88 буюу 3.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.


Д/д	Хороо	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	1-р хороо	32	8	67	10	29	
2	2-р хороо	4	1	6	1	5	
3	3-р хороо	9	7	19	4	8	
4	4-р хороо	9	5	13	3	7	
5	5-р хороо	6	1	3	3	3	
6	6-р хороо	13	3	28	7	6	
7	7-р хороо	5	4	30	2	9	
8	8-р хороо	17	4	70	6	20	
9	9-р хороо	21		21	9	7	
10	10-р хороо	2	7	9	2	4	1
11	11-р хороо	5	5	23	7	12	
12	12-р хороо		4	6	3	3	
13	13-р хороо	9	2	7	8	1	
14	14-р хороо	1		4	1	2	
15	15-р хороо	2		3	3		
16	16-р хороо	4	4	10	7	5	
17	17-р хороо	2		5	4	1	
18	18-р хороо		2	3	1	3	
19	19-р хороо	8	3	5	3	4	
20	20-р хороо	3	8	5	4	15	
	<b>Нийт</b>	<b>152</b>	<b>68</b>	<b>337</b>	<b>88</b>	<b>144</b>	<b>1</b>

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Сүхбаатар дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 931 буюу 40.7 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 47.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр өссөн.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 3.3 нэгжээр бага байна.



### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 1586 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 44 хэрэг буюу 2.7 хувиар буурч, үүнээс 745 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 31 буюу 4.3 хувиар өссөн байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 1648 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.0 хувиар өссөн. Холбогдогчдын 310 буюу 18.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 16.5, 1338 буюу 81.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 37.5, 98 буюу 5.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 24.1 хувиар тус тус өссөн байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 2235 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, үүнээс 33 хүн нас барж, 574 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 246 буюу 12.4, нас барсан хүн 12 буюу 57.1, гэмтсэн хүн 58 буюу 11.2 хувиар тус тус өссөн байна.



### 4.2 Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 42810.5 сая төгрөгийн хохирлын 63.8 хувийг нөхөн төлүүлж, 709.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 16881.0 сая төгрөг буюу 65.1 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 14924.3 сая төгрөг буюу 2.2 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 86.7 сая төгрөг буюу 10.9 хувиар буурсан байна.

## Тав. Зөрчил

Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын хэмжээнд нийт 51795 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 33312 буюу 2.8 дахин, 51600 зөрчлийг шийдвэрлэсэн нь 33144 буюу 2.8 дахин тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 37670 буюу 72.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 7523 буюу 14.5 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 549 буюу 1.1 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 410 буюу 0.8 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 5643 буюу 10.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 47788 иргэн, 590 хуулийн этгээдийг 2894774.0 мянган төгрөгөөр торгох, 779 хүнийг баривчлуулах, 2443 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 30582 буюу 2.7 дахин, хуулийн этгээд 4.3 дахин тус тус өсч, баривчилсан шийтгэл 333 буюу 29.9 хувиар буурсан байна.

---oooOooo---

## 2.4 СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 37691 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 9461 буюу 25.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 28230 буюу 74.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 3070 буюу 8.9 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 3186 буюу 12.7 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 116 буюу 1.2 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 8753 буюу 44.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 10015 буюу 50.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 261 буюу 1.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 43024 буюу 77.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 11008 буюу 19.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 923 буюу 1.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 8880 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 460 буюу 5.5 хувиар өсч, улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 34.9 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 9710, сард 809, хоногт 27, цагт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг, сүүлийн 10 жилээр:



#### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /аймгаар/.




Д/д	Аймаг	2020 он	2021 он	Өсөлт, бууралт		Д/д	Аймаг	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Архангай	435	412	-23	-5.3	12	Орхон	533	504	-29	-5.4
2	Баян-Өлгий	308	187	-121	-39.3	13	Өвөрхангай	407	458	51	12.5
3	Баянхонгор	462	428	-34	-7.4	14	Өмнөговь	458	453	-5	-1.1
4	Булган	349	388	39	11.2	15	Сүхбаатар	408	344	-64	-15.7
5	Говь-Алтай	151	231	80	53.0	16	Сэлэнгэ	549	637	88	16.0
6	Говьсүмбэр	148	135	-13	-8.8	17	Төв	737	611	-126	-17.1

7	Дархан-Уул	566	543	-23	-4.1	18	Увс	188	239	51	27.1
8	Дорноговь	318	490	172	54.1	19	Ховд	394	416	22	5.6
9	Дорнод	476	536	60	12.6	20	Хөвсгөл	535	716	181	33.8
10	Дундговь	196	245	49	25.0	21	Хэнтий	531	540	9	1.7
11	Завхан	271	367	96	35.4						

#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 7314 буюу 82.4 хувь нь хөнгөн, 1566 буюу 17.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 9.7 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 10.8 хувиар буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>13</sup>




#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	173	176	1.7	2.0
	Үүнээс: Хүнийг алах	97	85	-12.4	1.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2838	3085	8.7	34.7
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	46	69	50.0	0.8
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	249	271	8.8	3.1
	Үүнээс: Хүчиндэх	197	214	8.6	2.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	59	71	20.3	0.8
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	4	2	-50.0	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	6	8	33.3	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.0
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3703	3834	3.5	43.2
	Хулгайлах	1619	1296	-20.0	14.6
	Дээрэмдэх	63	61	-3.2	0.7
	Залилах	646	1306	2.0 дах	14.7
	Мал хулгайлах	978	694	-29.0	7.8
9	Эдийн засгийн гэмт хэрэг	53	28	-47.2	0.3
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	53	222	4.2 дах	2.5
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	30	18	-40.0	0.2
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	4	14	3.5 дах	0.2
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	85	95	11.8	1.1
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	570	549	-3.7	6.2
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	0.0
17	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	27	18	-33.3	0.2
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	554	472	-14.8	5.3
18	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	551	470	-14.7	5.3
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	3	9	30.0 дах	0.1

<sup>13</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.


### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1254 буюу 14.1 хувь нь даваа гарагт, 1338 буюу 15.1 хувь нь мягмар гарагт, 1341 буюу 15.1 хувь нь лхагва гарагт, 1366 буюу 15.4 хувь нь пүрэв гарагт, 1284 буюу 14.5 хувь нь баасан гарагт, 1125 буюу 12.7 хувь нь бямба гарагт, 1172 буюу 13.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1965 буюу 22.1 хувь нь 06:00-14:00 цагт, 2689 буюу 30.3 хувь нь 14:00-19:00 цагт, 1536 буюу 17.3 хувь нь 19:00-22:00 цагт, 2690 буюу 30.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 3381 буюу 38.1 хувь нь гэр орон сууцанд, 961 буюу 10.8 хувь нь гудамж талбайд, 389 буюу 4.4 хувь нь олон нийтийн газарт, 10 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 120 буюу 1.4 хувь нь төрийн байгууллагад, 38 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 285 буюу 3.2 хувь нь аж ахуйн нэгжид, 449 буюу 5.1 хувь нь авто замд, 3247 буюу 36.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 2723 буюу 30.7 хувь нь согтуугаар, 773 буюу 8.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 600 буюу 6.7 хувь нь бүлэглэн, 243 буюу 2.7 хувь нь хүүхэд оролцож, 679 буюу 7.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.


Д/д	Аймаг	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Архангай	106	11	32	31	33	3
2	Баян-Өлгий	47	10	10	11	10	
3	Баянхонгор	171	18	44	46	40	1
4	Булган	121	14	35	16	38	2
5	Говь-Алтай	55	8	24	20	20	2
6	Говьсүмбэр	66	1	29	11	3	
7	Дархан-Уул	193	18	60	72	34	
8	Дорноговь	130	18	50	33	30	1
9	Дорнод	124	5	37	32	33	
10	Дундговь	89	10	15	16	31	
11	Завхан	102	8	31	20	35	3
12	Орхон	177	17	58	31	36	
13	Өвөрхангай	163	7	37	47	48	2
14	Өмнөговь	154	5	44	19	25	1
15	Сүхбаатар	107	7	32	41	12	
16	Сэлэнгэ	188	15	61	60	37	
17	Төв	154	9	31	59	25	2
18	Увс	73	7	19	10	19	3
19	Ховд	123	24	26	33	26	2
20	Хөвсгөл	185	20	56	34	23	4
21	Хэнтий	195	11	42	37	42	4
	<b>Нийт</b>	<b>2723</b>	<b>243</b>	<b>773</b>	<b>679</b>	<b>600</b>	<b>30</b>

## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Орон нутагт нийт бүртгэгдсэн хэргийн 3645 буюу 41.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 58.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгжээр буусан.

Улсын илрүүлэлттэй харьцуулахад 6.2 нэгжээр их байна.



### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 5527 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 251 хэрэг буюу 4.3 хувиар, үүнээс 3255 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 168 буюу 4.9 хувиар тус тус буурсан байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэгт нийт 7509 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.2 хувиар өссөн.

Холбогдогчдын 767 буюу 10.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар, 6742 буюу 89.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 3.2 хувиар тус тус өсч, 327 буюу 4.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 2.7 хувиар буурсан байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 8921 иргэн, 27 хуулийн этгээд хохирч, үүнээс 344 хүн нас барж, 3622 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 346 буюу 4.0, гэмтсэн хүн 210 буюу 6.2 хувиар тус тус өсч, нас барсан хүн 41 буюу 10.6 хувиар, хуулийн этгээд 18 буюу 40.0 хувиар тус тус буурсан байна.



## 4.2 Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 30182.2 сая төгрөгийн хохирлын 54.2 хувийг нөхөн төлүүлж, 3014.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс нөхөн төлүүлсэн хохирол 1506.7 сая буюу 10.1 хувиар өсч, хохирлын хэмжээ 2370.4 сая төгрөг буюу 7.3 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 469.6 сая төгрөг буюу 13.5 хувиар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 1506.7 сая төгрөг буюу 10.1 хувиар өссөн байна.

## Тав. Зөрчил

Орон нутаг дахь цагдаагийн байгууллагуудын хэмжээнд нийт 471.799 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 52019 буюу 9.9 хувиар, 470125 зөрчлийг шийдвэрлэсэн нь 52397 буюу 10.0 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 420.569 буюу 89.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 9318 буюу 2.0 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 3251 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 218 буюу 0.1 хувь нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 38443 буюу 8.1 хувь нь бусад төрлийн зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 445.504 иргэн, 155 хуулийн этгээдийг 22102877.0 мянган төгрөгөөр торгох, 8043 хүнийг баривчлуулах, 16423 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 56641 буюу 11.3 хувиар, баривчилсан шийтгэл 448 буюу 5.3 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 4683 буюу 39.9 хувиар, торгуулсан хуулийн этгээд 9 буюу 6.2 хувиар тус тус өссөн байна.

2021 онд орон нутгийн хэмжээнд нийт 15477 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8658 буюу 35.9 хувиар буурсан байна.

---oooOooo---

### 3.1 АРХАНГАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

#### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Архангай аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 2319 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 835 буюу 36.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1484 буюу 64.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 242 буюу 11.7 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 259 буюу 21.1 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 17 буюу 2.0 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 410 буюу 49.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 388 буюу 46.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 6 буюу 0.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1238 буюу 83.4 хувийг зөрчлийн хэрэг нээж, 215 буюу 14.5 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 12 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 412 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23 буюу 5.3 хувиар бүүрч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.6 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 82, сард 40, 2 хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



##### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.




Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт Тоо	Хувь	Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт Тоо	Хувь
1	Батцэнгэл	21	11	-10	-47.6	11	Хангай	1	6	5	6.0 дах
2	Булган	18	17	-1	-5.6	12	Хашаат	13	8	-5	-38.5
3	Жаргалант	1	7	6	7.0 дах	13	Хотонт	22	21	-1	-4.5
4	Их тамир	44	33	-11	-25.0	14	Цахир	6	7	1	16.7
5	Өгийнуур	14	13	-1	-7.1	15	Цэнхэр	40	34	-6	-15.0
6	Өлзийт	17	16	-1	-5.9	16	Цэцэрлэг	17	5	-12	-70.6

7	Өндөр-Улаан	12	20	8	66.7	17	Чулуут	8	6	-2	-25.0
8	Тариат	26	16	-10	-38.5	18	Эрдэнэбулган	135	149	14	10.4
9	Төвшрүүлэх	14	20	6	42.9	19	Эрдэнэмандал	14	14		
10	Хайрхан	12	9	-3	-25.0						

#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 318 буюу 77.2 хувь нь хөнгөн, 94 буюу 22.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 0.9 хувиар, хүнд гэмт хэрэг 17.5 хувиар тус тус буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>14</sup>



#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	9	9	0.0	2.2
	Үүнээс: Хүнийг алах	6	5	-16.7	1.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	134	124	-7.5	30.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	4	4.0 дах	1.0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	9	-18.2	2.2
	Үүнээс: Хүчиндэх	8	8		1.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	4		1.0
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1			
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.5
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	193	170	-11.9	41.3
	Хулгайлах	70	64	-8.6	15.5
	Дээрэмдэх	2			
	Залилах	13	35	2.6 дах	8.5
9	Мал хулгайлах	102	65	-36.3	15.8
	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	5	25.0	1.2
10	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг		4		1.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		6		1.5
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.5
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	26	45	73.1	10.9
14	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1		-100.0	0.0
15	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	19	5	-73.7	1.2
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	31	26	-16.1	6.3
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	31	26	-16.1	6.3

#### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 59 буюу 14.3 хувь нь даваа гарагт, 57 буюу 13.8 хувь нь мягмар гарагт, 72 буюу 17.5 хувь нь лхагва гарагт, 62 буюу 15.0 хувь нь пүрэв гарагт, 55 буюу 13.3 хувь нь баасан гарагт, 49 буюу 11.9 хувь нь бямба гарагт, 58 буюу 14.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 80 буюу 19.4 хувь нь 06:00-14:00 цагт, 110 буюу 26.7 хувь нь 14:00-19:00 цагт, 67 буюу 16.6 хувь нь 19:00-22:00 цагт, 155 буюу 37.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.


<sup>14</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.





### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 142 буюу 34.5 хувь нь гэр орон сууцанд, 40 буюу 9.7 хувь нь гудамж талбайд, 8 буюу 1.9 хувь нь олон нийтийн газарт, 4 буюу 1.0 хувь нь аж ахуйн нэгжид, 26 буюу 6.3 хувь нь авто замд, 192 буюу 46.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 106 буюу 25.5 хувь нь согтуугаар, 32 буюу 7.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 33 буюу 7.9 хувь нь бүлэглэн, 11 буюу 2.6 хувь нь хүүхэд оролцож, 31 буюу 7.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Батцэнгэл	4		1	1		
2	Булган	3				3	
3	Жаргалант			2		1	
4	Их тамир	8		3	2	3	2
5	Өгийнуур	3				1	
6	Өлзийт	7	1	1		3	
7	Өндөр улаан	1		1	1	3	1
8	Тариат	2	1	2	2	2	
9	Төвшрүүлэх	3				1	
10	Хайрхан	3			1		
11	Хангай	1			1		
12	Хашаат	5		2		1	
13	Хотонт	6	1	1	2	2	
14	Цахир	2		2			
15	Цэнхэр	8		1	2	4	
16	Цэцэрлэг	1					
17	Чулуут	1		1			
18	Эрдэнэбулган	43	7	13	19	7	
19	Эрдэнэмандал	5	1	2		2	
	<b>Нийт</b>	<b>106</b>	<b>11</b>	<b>32</b>	<b>31</b>	<b>33</b>	<b>3</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Архангай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 178 буюу 43.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 57.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.4 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.4 нэгжээр бага байна.



## 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 228 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 41 хэрэг буюу 15.2 хувиар, үүнээс 131 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 17 буюу 11.5 хувиар тус тус буурсан байна.

### Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

#### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 359 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Холбогдогчдын 28 буюу 7.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өсч, 331 буюу 92.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 0.9 хувиар, 15 буюу 4.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 37.5 хувиар тус тус буурсан байна.


#### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



### Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 4.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 416 иргэн хохирч, үүнээс 22 хүн нас барж, 148 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 33 буюу 7.3, гэмтсэн хүн 14 буюу 8.6 хувиар тус тус буурч, нас барсан хүн өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.



#### 4.2 Учирсан хохирол.




Иргэдэд учирсан 1350.5 сая төгрөгийн хохирлын 56.3 хувийг нөхөн төлүүлж, 42.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 295.0 сая төгрөг буюу 17.9, нөхөн төлүүлсэн хохирол 46.6 сая төгрөг буюу 5.8 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 43.2 сая төгрөг буюу 50.5 хувиар тус тус буурсан байна.

### Тав. Зөрчил

Архангай аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 19445 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7986 буюу 29.1 хувиар, 19387 зөрчлийг шийдвэрлэсэн нь 8035 буюу 29.3 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 16744 буюу 86.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 390 буюу 2.0 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 203 буюу 1.0 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2108 буюу 10.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 18480 иргэн, 1 хуулийн этгээдийг 746038.3 мянган төгрөгөөр торгох, 399 хүнийг баривчлуулах, 507 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 8141 буюу 30.6 хувиар буурч, баривчлуулсан шийтгэл 11 буюу 2.8 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 94 буюу 22.8 хувиар тус тус өссөн байна.

2021 онд Архангай аймагт нийт 268 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 148 буюу 2.2 дахин өссөн байна.

---oooOooo---

## 3.2 БАЯН-ӨЛГИЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 2927 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 612 буюу 20.9 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2315 буюу 79.1 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 384 буюу 15.1 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 26 буюу 4.4 хувиар зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 358 буюу 18.3 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 216 буюу 32.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 365 буюу 59.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 20 буюу 3.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1878 буюу 81.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 407 буюу 17.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 19 буюу 0.8 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 187 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 121 буюу 39.3 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.1 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 310, сард 25, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



#### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.


Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алтай	12	7	-5	-41.7
2	Алтанцөгц	9	1	-8	-88.9
3	Баяннуур	15	7	-8	-53.3
4	Булган	7	7	0	0.0
5	Буянт	10	6	-4	-40.0
6	Цэнгэл	22	14	-8	-36.4
7	Бугат	16	9	-7	-43.8
8	Дэлүүн	9	4	-5	-55.6
9	Ногооннуур	25	16	-9	-36.0
10	Өлгий	146	95	-51	-34.9
11	Сагсай	15	7	-8	-53.3
12	Толбо	9	6	-3	-33.3
13	Улаанхус	13	8	-5	-39.3



#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 135 буюу 72.2 хувь нь хөнгөн, 52 буюу 27.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 44.9 хувиар, хүнд гэмт хэрэг 17.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>15</sup>




## 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	6	3	-50.0	1.6
	Үүнээс: Хүнийг алах	4	2	-50.0	1.1
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	116	54	-53.4	28.9
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	1	-50.0	0.5
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	6	5	-16.7	2.7
	Үүнээс: Хүчиндэх	3	4	33.3	2.1
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	2			0.0
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3			0.0
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			0.0
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	135	93	-31.1	49.7
	Хулгайлах	55	26	-52.7	13.9
	Дээрэмдэх		3		1.6
	Залилах	31	22	-29.0	11.8
	Мал хулгайлах	27	21	-22.2	11.2
8	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			0.0
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.5
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1			0.0
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	10	10.0 дах	5.3
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	16	5	-68.8	2.7
13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1			0.0
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	18	16	-11.1	8.6
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	17	16	-5.9	8.6

## 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 29 буюу 15.5 хувь нь даваа гарагт, 38 буюу 20.3 хувь нь мягмар гарагт, 21 буюу 11.2 хувь нь лхагва гарагт, 35 буюу 18.7 хувь нь пүрэв гарагт, 28 буюу 15.0 хувь нь баасан гарагт, 17 буюу 9.1 хувь нь бямба гарагт, 19 буюу 10.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 37 буюу 19.8 хувь нь 06:00-14:00 цагт, 72 буюу 38.5 хувь нь 14:00-19:00 цагт, 30 буюу 16.0 хувь нь 19:00-22:00 цагт, 48 буюу 25.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



<sup>15</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 54 буюу 28.9 хувь нь гэр орон сууцанд, 25 буюу 13.4 хувь нь гудамж талбайд, 21 буюу 11.2 хувь нь олон нийтийн газарт, 5 буюу 2.7 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 1.1 хувь нь төрийн бус байгууллагад, 5 буюу 2.7 хувь нь аж ахуйн нэгжид, 14 буюу 7.5 хувь нь авто замд, 61 буюу 32.6 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 47 буюу 25.1 хувь нь согтуугаар, 10 буюу 5.3 хувь нь хүүхэд оролцож, 10 буюу 5.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 11 буюу 5.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 10 буюу 5.3 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.


Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн
1	Алтай	3			1	
2	Алтанцөгц					
3	Баяннуур	3		1		1
4	Булган					
5	Буянт		1			
6	Цэнгэл	3	1			1
7	Бугат	2			1	1
8	Дэлүүн					
9	Ногооннуур	3	1		1	1
10	Өлгий	29	5	9	6	5
11	Сагсай	1	2			1
12	Толбо	1				
13	Улаанхус	2			2	
<b>Нийт</b>		<b>47</b>	<b>10</b>	<b>10</b>	<b>11</b>	<b>10</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Баян-Өлгий аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 71 буюу 38.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 79.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.1 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 20.2 нэгжээр өндөр байна.



#### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 134 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 138 хэрэг буюу 50.7 хувиар, үүнээс 106 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 115 буюу 52.0 хувиар тус тус буурсан байна.


### Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

#### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 188 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 48.6 хувиар буурсан.

Холбогдогчдын 13 буюу 6.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 59.4 хувиар, 175 буюу 93.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 47.6 хувиар, 12 буюу 6.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 60.0 хувиар тус тус буурсан байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




### Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 198 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, үүнээс 12 хүн нас барж, 68 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 115 буюу 36.7, нас барсан хүн 3 буюу 20.0, гэмтсэн хүн 67 буюу 49.6 хувиар тус тус буурсан байна.



#### 4.2 Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 761.8 сая төгрөгийн хохирлын 84.9 хувийг нөхөн төлүүлж, 93.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 61.1 сая төгрөг буюу 7.4, битүүмжилсэн хөрөнгө 3.8 сая төгрөг буюу 3.9 хувиар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 97.4 сая төгрөг буюу 17.7 хувиар өссөн байна.

### Тав. Зөрчил

Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 18315 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6082 буюу 49.7 хувиар өсч, 18345 зөрчлийг шийдвэрлэсэн нь 6115 буюу 50.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 16039 буюу 87.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 936 буюу 5.1 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 170 буюу 0.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 53 буюу 0.3 хувь нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 1170 буюу 6.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 17615 иргэнийг 766733.1 мянган төгрөгөөр торгох, 263 хүнийг баривчлуулах, 467 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 5922 буюу 50.6 хувиар, баривчлуулсан шийтгэл 4 буюу 1.5 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 190 буюу 68.6 хувиар тус тус өссөн байна.

2021 онд Баян-Өлгий аймагт нийт 961 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 81 буюу 7.8 хувиар буурсан байна.

### 3.3 БАЯНХОНГОР АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

#### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Баянхонгор аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 4516 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1066 буюу 23.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3450 буюу 76.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 328 буюу 6.8 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 408 буюу 10.5 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 80 буюу 8.1 хувиар өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 331 буюу 31.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 676 буюу 63.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 11 буюу 1.0 хувийг харъяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2660 буюу 71.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 676 буюу 19.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 58 буюу 1.7 хувийг харъяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 428 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 34 буюу 7.4 хувиар буурч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.8 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 459, сард 38, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



##### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баацагаан	13	23	10	76.9
2	Баян овоо	24	17	-7	-29.2
3	Баянбулаг	1			
4	Баянговь	6	4	-2	-33.3
5	Баянлиг	8	12	4	50.0
6	Баянөндөр	6	8	2	33.3
7	Баянхонгор	211	239	28	13.3
8	Баянцагаан	3	6	3	2.0 дах
9	Богд	8	5	-3	-37.5
10	Бөмбөгөр	49	28	-21	-42.9
11	Бууцагаан	19	14	-5	-26.3
12	Галуут	16	13	-3	-18.8
13	Гурванбулаг	6	10	4	66.7
14	Жаргалант	9	13	4	44.4
15	Жинст	9	8	-1	-11.1
16	Шинэжинст	6	1	-5	-83.3
17	Эрдэнэцогт	16	10	-6	-37.5
18	Заг	11	7	-4	-36.4
19	Өлзийт	36	9	-27	-75.0
20	Хүрээмарал	5	1	-4	-80.0






#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 352 буюу 82.2 хувь нь хөнгөн, 76 буюу 17.8 хувь нь хүнд ангилалын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 2.8 хувиар, хүнд гэмт хэрэг 24.0 хувиар тус тус буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>16</sup>




#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	7	6	-14.3	1.4
	Үүнээс: Хүнийг алах	2	3	50.0	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	143	179	25.2	41.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2			
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	30	21	-30.0	4.9
	Үүнээс: Хүчиндэх	22	16	-27.3	3.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг		2		0.3
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	192	145	-24.5	34.2
	Үүнээс: Хулгайлах	80	67	-16.3	15.7
	Залилах	28	38	35.7	8.9
	Дээрэмдэх	1	4	4.0 дах	0.9
	Мал хулгайлах	66	21	-68.2	4.9
7	Эдийн засгийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.5
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	17	8.5 дах	4.0
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	1	-75.0	0.2
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	7	40.0	1.6
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	53	27	-49.1	6.3
12	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		1		0.2
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	25	19	-24.0	4.4
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	24	19	-20.8	4.4

#### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 57 буюу 13.3 хувь нь даваа гарагт, 73 буюу 17.1 хувь нь мягмар гарагт, 65 буюу 15.2 хувь нь лхагва гарагт, 60 буюу 14.0 хувь нь пүрэв гарагт, 72 буюу 16.8 хувь нь баасан гарагт, 45 буюу 10.5 хувь нь бямба гарагт, 56 буюу 13.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 97 буюу 22.7 хувь нь 06:00-14:00 цагт, 127 буюу 29.7 хувь нь 14:00-19:00 цагт, 96 буюу 22.4 хувь нь 19:00-22:00 цагт, 108 буюу 25.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



<sup>16</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 184 буюу 43.0 хувь нь гэр орон сууцанд, 40 буюу 9.3 хувь нь гудамж талбайд, 28 буюу 6.5 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 5 буюу 1.2 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 4 буюу 0.9 хувь нь аж ахуйн нэгжид, 15 буюу 3.5 хувь нь авто замд, 149 буюу 34.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 171 буюу 41.5 хувь нь согтуугаар, 44 буюу 10.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 40 буюу 9.7 хувь нь бүлэглэн, 18 буюу 4.4 хувь нь хүүхэд оролцож, 46 буюу 11.23 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 1 буюу 0.2 хувь нь галт зэвсгээр тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баацагаан	4	1	6	3	6	1
2	Баян-Овоо	5			2	4	
3	Баянбулаг						
4	Баянговь	3					
5	Баянлиг	3		1	2	1	
6	Баян-Өндөр	1	1		2	3	
7	Баянхонгор	121	8	30	30	12	
8	Баянцагаан	2		2		1	
9	Богд	1	1				
10	Бөмбөгөр	6	1		1	4	
11	Бууцагаан	4		1			
12	Галуут	5		1		3	
13	Гурванбулаг	3					
14	Жаргалант	3	4	2	1	4	
15	Жинст		1				
16	Шинэжинст						
17	Эрдэнэцогт	4		1	2		
18	Заг	2	1			1	
19	Өлзийт	3			3	1	
20	Хүрээмарал	1					
<b>Нийт</b>		<b>171</b>	<b>18</b>	<b>44</b>	<b>46</b>	<b>40</b>	<b>1</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Баянхонгор аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 145 буюу 33.9 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 56.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 2.2 нэгжээр бага байна.



#### 2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 210 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 95 хэрэг буюу 31.1 хувиар, үүнээс 119 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 57 буюу 32.4 хувиар тус тус буурсан байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 391 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 хувиар буурсан.

Холбогдогчдын 45 буюу 11.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 21.6 хувиар, 27 буюу 6.9 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 50.0 хувиар тус тус өсч, 346 буюу 88.5 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 4.7 хувиар буурсан байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 433 иргэн хохирч, үүнээс 14 хүн нас барж, 196 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 43 буюу 9.0 хувиар буурч, нас барсан хүн өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, гэмтсэн хүн 25 буюу 14.6 хувиар өссөн байна.




### 4.2. Учирсан хохирол.



Иргэдэд учирсан 999.8 сая төгрөгийн хохирлын 43.8 хувийг нөхөн төлүүлж, 159.7 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 168.2 сая төгрөг буюу 14.4 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 172.2 сая төгрөг буюу 28.2 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 313.9 сая төгрөг буюу 66.3 хувиар тус тус буурсан байна.

## Тав. Зөрчил

Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 17722 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8699 буюу 32.9 хувиар, 17587 зөрчлийг шийдвэрлэсэн нь 8756 буюу 33.2 хувиар тус тус буурсан байна.



Нийт бүртгэгдсэн зөрчлийн 16007 буюу 90.3 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 48 буюу 0.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 206 буюу 1.2 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1461 буюу 8.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 16138 иргэнийг 1001949.7 мянган төгрөгөөр торгох, 562 хүнийг баривчлуулах, 887 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 25260 буюу 36.1 хувиар буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 272 буюу 44.2 хувиар, баривчлуулсан шийтгэл 96 буюу 20.6 хувиар тус тус өссөн байна.

2021 онд Баянхонгор аймагт нийт 844 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 204 буюу 19.5 хувиар буурсан байна.

---oooOooo---

### 3.4 БУЛГАН АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

#### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Булган аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 3331 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 675 буюу 20.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2656 буюу 79.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 640 буюу 23.8 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 36 буюу 5.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 604 буюу 29.4 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 401 буюу 59.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 237 буюу 35.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 14 буюу 2.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2457 буюу 92.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 164 буюу 6.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 8 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 388 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 39 буюу 11.2 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.4 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 350, сард 29, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



##### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.




Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баян-Агт	10	15	5	50.0
2	Баяннуур	4	9	5	2.2 дах
3	Бугат	27	25	-2	-7.4
4	Булган	66	68	2	3.0
5	Бүрэгхангай	36	33	-3	-8.3
6	Гурванбулаг	21	24	3	14.3
7	Дашинчилэн	12	18	6	50.0
8	Могод	6	11	5	83.3
9	Орхон	37	53	16	43.2
10	Рашаант	11	9	-2	-18.2
11	Сайхан	16	14	-2	-12.5
12	Сэлэнгэ	17	26	9	52.9
13	Тэшиг	6	9	3	50.0
14	Хангал	37	25	-12	-32.4
15	Хишиг-Өндөр	17	22	5	29.4
16	Хутаг-Өндөр	26	27	1	3.8

##### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 312 буюу 80.4 хувь нь хөнгөн, 76 буюу 19.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 13.9 хувиар, хүнд гэмт хэрэг 1.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>17</sup>




### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	11	15	36.4	3.9
	Үүнээс: Хүнийг алах	5	11	2.2 дах	2.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	100	107	7.0	27.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1			
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	16	19	18.8	4.9
	Үүнээс: Хүчиндэх	15	14	-6.7	3.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		3		0.8
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	140	136	-2.9	35.1
5	Үүнээс: Хулгайлах	54	49	-9.3	12.6
	Дээрэмдэх	1			
	Залилах	15	23	53.3	5.9
	Мал хулгайлах	52	40	-23.1	10.3
6	Эдийн засгийн гэмт хэрэг	7			
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		3		0.8
	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		4		1.0
9	Авлигын эсрэг гэмт хэрэг		1		0.3
10	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		2		0.5
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	47	73	55.3	18.8
12	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг		1		0.3
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	28	24	-14.3	6.2
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	28	24	-14.3	6.2

### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 49 буюу 12.6 хувь нь даваа гарагт, 47 буюу 12.1 хувь нь мягмар гарагт, 63 буюу 16.2 хувь нь лхагва гарагт, 62 буюу 16.0 хувь нь пүрэв гарагт, 55 буюу 14.2 хувь нь баасан гарагт, 48 буюу 12.4 хувь нь бямба гарагт, 64 буюу 16.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 58 буюу 14.9 хувь нь 06:00-14:00 цагт, 137 буюу 35.3 хувь нь 14:00-19:00 цагт, 65 буюу 16.8 хувь нь 19:00-22:00 цагт, 128 буюу 33.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



<sup>17</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 115 буюу 29.6 хувь нь гэр орон сууцанд, 23 буюу 5.9 хувь нь гудамж талбайд, 12 буюу 3.1 хувь нь олон нийтийн газарт, 4 буюу 1.0 хувь нь аж ахуйн нэгжид, 20 буюу 5.1 хувь нь авто замд, 214 буюу 55.3 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 121 буюу 31.2 хувь нь согтуугаар, 14 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 35 буюу 9.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 16 буюу 4.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 38 буюу 9.8 хувь нь бүлэглэн, 2 буюу 0.5 хувийг галт зэвсгээр үйлдэгдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баян Агт сум	4	1			1	
2	Баяннуур сум	2	2			1	
3	Бугат сум	5	1	5	4	6	1
4	Булган сум	28	2	5	6	3	
5	Бүрэг хангай сум	10			1	3	
6	Гурванбулаг сум	8		1	1	2	
7	Дашинчилэн сум	2	1	1		6	
8	Могод сум	3				1	
9	Орхон сум	19	2	8	2	4	
10	Рашаант сум	2		1		1	
11	Сайхан сум	7		1	1		
12	Сэлэнгэ сум	3	1	5		2	
13	Тэшиг сум	2		2	1	2	
14	Хангал сум	12		2		2	
15	Хишигөндөр сум	8	4	2		2	1
16	Хутаг өндөр сум	6		2		2	
	<b>Нийт</b>	<b>121</b>	<b>14</b>	<b>35</b>	<b>16</b>	<b>38</b>	<b>2</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Булган аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 101 буюу 26.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 54.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.4 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 4.3 нэгжээр бага байна.



#### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 229 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 22 хэрэг буюу 8.8 хувиар, үүнээс 125 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6 буюу 4.6 хувиар тус тус буурсан байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 344 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.3 хувиар өссөн.

Холбогдогчдын 34 буюу 9.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар, 310 буюу 90.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 34.2 хувиар, 26 буюу 7.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 73.3 хувиар тус тус өссөн байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 402 иргэн хохирч, үүнээс 29 хүн нас барж, 131 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 47 буюу 13.2, нас барсан хүн 13 буюу 81.3 хувиар, гэмтсэн хүн 9 буюу 7.4 хувиар тус тус өссөн байна.




### 4.2 Учирсан хохирол.



Иргэдэд учирсан 2716.9 сая төгрөгийн хохирлын 30.4 хувийг нөхөн төлүүлж, 371.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 1113.2 сая төгрөг буюу 69.4, битүүмжилсэн хөрөнгө 163.0 сая төгрөг буюу 78.2 хувиар тус тус өссөн, нөхөн төлүүлсэн хохирол 65.5 сая төгрөг буюу 7.3 хувиар буурсан байна.

## Тав. Зөрчил

Булган аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 20297 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5783 буюу 22.2, 20263 зөрчлийг шийдвэрлэсэн нь 5749 буюу 22.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.





Нийт бүртгэгдсэн зөрчлийн 18229 буюу 89.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 457 буюу 2.3 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 213 буюу 1.0 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1398 буюу 6.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчил гаргасан 19262 иргэн, 1 хуулийн этгээдийг 971656.8 мянган төгрөгөөр торгох, 396 хүнийг баривчлуулах, 604 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 5935 буюу 23.6 хувиар, баривчлуулсан шийтгэл 3 буюу 0.8 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 195 буюу 47.7 хувиар өссөн.

2021 онд Булган аймагт нийт 787 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 41 буюу 5.0 хувиар буурсан байна.

---oooOooo---

### 3.5 ГОВЬ-АЛТАЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

#### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 2011 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 525 буюу 26.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1486 буюу 73.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 623 буюу 44.9 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 46 буюу 9.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 577 буюу 63.5 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 187 буюу 35.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 314 буюу 59.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 15 буюу 2.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1258 буюу 84.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 213 буюу 14.3 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 14 буюу 0.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 231 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 80 буюу 53.0 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.6 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 197, сард 16, хоногт 1 хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



##### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.




Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алтай	2	12	10	6.0 дах
2	Баянуул	5	6	1	20.0
3	Бигэр	8	6	-2	-25.0
4	Бугат	4	6	2	50.0
5	Дарви	2	1	-1	-50.0
6	Дэлгэр	15	9	-6	-40.0
7	Есенбулаг	71	118	47	66.2
8	Жаргалан	8	6	-2	-25.0
9	Тайшир	5	4	-1	-20.0
10	Тонхил	4	4	0	0.0
11	Төгрөг	1	3	2	3.0 дах
12	Халиун	6	9	3	50.0
13	Хөхморьт		4	4	
14	Цогт	7	10	3	42.9
15	Цээл	1	6	5	6.0 дах
16	Чандмань	3	4	1	33.3
17	Шарга	7	9	2	28.6
18	Эрдэнэ	2	14	12	7.0 дах

##### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 186 буюу 80.5 хувь нь хөнгөн, 45 буюу 19.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 67.6 хувиар, хүнд гэмт хэрэг 12.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>18</sup>




### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	6	2.0 дах	2.6
	Үүнээс: Хүнийг алах	2	4	2.0 дах	1.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	44	76	72.7	32.9
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		1		0.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	5	7	40.0	3.0
	Үүнээс: Хүчиндэх	5	7	40.0	3.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.4
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	79	104	31.6	45.1
	Үүнээс: Хулгайлах	45	40	-11.1	17.3
	Дээрэмдэх	1			
	Залилах	20	49	2.5 дах	21.2
	Мал хулгайлах	9	8	-11.1	3.5
6	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		9		3.9
7	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1			
8	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг				
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	10	12	20.0	5.2
10	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	8	15	87.5	6.5
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	8	14	75.0	6.1
	Цэргийн эсрэг гэмт хэрэг		1		0.4

### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 46 буюу 19.9 хувь нь даваа гарагт, 33 буюу 14.3 хувь нь мягмар гарагт, 41 буюу 17.7 хувь нь лхагва гарагт, 34 буюу 14.7 хувь нь пүрэв гарагт, 31 буюу 13.4 хувь нь баасан гарагт, 20 буюу 8.7 хувь нь бямба гарагт, 26 буюу 11.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 49 буюу 21.2 хувь нь 06:00-14:00 цагт, 88 буюу 38.1 хувь нь 14:00-19:00 цагт, 37 буюу 16.0 хувь нь 19:00-22:00 цагт, 57 буюу 24.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



<sup>18</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 76 буюу 32.9 хувь нь гэр орон сууцанд, 18 буюу 7.8 хувь нь гудамж талбайд, 13 буюу 5.6 хувь нь олон нийтийн газарт, 9 буюу 3.9 хувь нь аж ахуйн нэгжид, 6 буюу 2.6 хувь нь төрийн байгууллагад, 16 буюу 6.9 хувь нь авто замд, 93 буюу 40.3 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 55 буюу 23.8 хувь нь согтуугаар, 2 буюу 0.9 хувь нь галт зэвсгээр, 8 буюу 3.5 хувь нь хүүхэд оролцож, 24 буюу 10.4 хувь нь эмэгтэй хүн оролцож, 20 буюу 8.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 20 буюу 8.7 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.


Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Алтай	1	1	1			1
2	Баянуул			1		1	1
3	Бигэр	1					
4	Бугат	2			1		
5	Дарви						
6	Дэлгэр				2	3	
7	Есөнбулаг	39	5	20	13	9	
8	Жаргалан	2					
9	Тайшир				1	1	
10	Тонхил	1					
11	Төгрөг						
12	Халиун	4					
13	Хөхморьт	1			1		
14	Цогт	3	1	1	1		
15	Цээл						
16	Чандмань		1	1	1		
17	Шарга					2	
18	Эрдэнэ	1				4	
	<b>Нийт</b>	<b>55</b>	<b>8</b>	<b>24</b>	<b>20</b>	<b>20</b>	<b>2</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Говь-Алтай аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 115 буюу 49.8 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 62.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 3.7 нэгжээр өндөр байна.



#### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 155 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 59 хэрэг буюу 61.5 хувиар, үүнээс 97 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 40 буюу 70.2 хувиар тус тус өссөн байна.

### Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

#### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 212 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.8 хувиар өссөн.

Холбогдогчдын 19 буюу 9.0 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 46.2 хувиар, 193 буюу 91.0 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 35.9 хувиар тус тус өсч, 9 буюу 4.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн 69.0 хувиар буурсан байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




### Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 4.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 238 иргэн хохирч, үүнээс 8 хүн нас барж, 94 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 73 буюу 44.2, нас барсан хүн 2 буюу 33.3 хувиар, гэмтсэн хүн 42 буюу 80.8 хувиар тус тус өссөн байна.



#### 4.2 Учирсан хохирол.




Иргэдэд учирсан 681.8 сая төгрөгийн хохирлын 83.7 хувийг нөхөн төлүүлж, 117.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 15.2 сая төгрөг буюу 2.2 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 70.2 сая буюу 14.0, битүүмжилсэн хөрөнгө 50.1 сая буюу 74.3 хувиар тус тус өссөн байна.

### Тав. Зөрчил

Төв аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 36157 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6895 буюу 16.0 хувиар, 36024 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6943 буюу 16.2 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 32697 буюу 90.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 321 буюу 0.9 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 260 буюу 0.7 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 51 буюу 0.1 хувь нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 2828 буюу 7.8 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 34455 иргэн, 1 хуулийн этгээдийг 1672873.0 мянган төгрөгөөр торгох, 475 хүнийг баривчлуулах, 1093 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 7293 буюу 17.5 хувиар, баривчлуулсан шийтгэл 35 буюу 6.9 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 386 буюу 54.6 хувиар өссөн байна.

2021 онд Төв аймагт нийт 119 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 176 буюу 59.7 хувиар буурсан байна.

---oooOooo---

### 3.18 УВС АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

#### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг


##### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Увс аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 3453 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 801 буюу 23.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2652 буюу 76.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 1860 буюу 2.2 дахин, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 1503 буюу 2.3 дахин, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 357 буюу 80.4 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 258 буюу 32.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 478 буюу 59.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 43 буюу 5.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2119 буюу 79.9 хувийг зөрчлийн хэрэг нээж, 461 буюу 17.4 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 29 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 239 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 51 буюу 27.1 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 314, сард 26, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.



##### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.




##### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 185 буюу 77.4 хувь нь хөнгөн, 54 буюу 22.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 32.1 хувиар, хүнд гэмт хэрэг 12.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баруунтуруун	4	4	0	0.0	11	Өндөрхангай	8	11	3	37.5
2	Бөхмөрөн	1	7	6	7.0 дах	12	Сагил	10	14	4	40.0
3	Давст	4	6	2	50.0	13	Тариалан	10	8	-2	-20.0
4	Завхан	6	2	-4	-66.7	14	Түргэн	5	9	4	80.0
5	Зүүнговь	1	6	5	6.0 дах	15	Тэс	16	13	-3	-18.8
6	Зүүнхангай	6	5	-1	-16.7	16	Улаангом	69	93	24	34.8
7	Малчин	7	12	5	71.4	17	Ховд	7	6	-1	-14.3
8	Наранбулаг	10	16	6	60.0	18	Хяргас	1	5	4	5.0 дах
9	Өлгий	5	6	1	20.0	19	Цагаанхайрхан	11	5	-6	-54.5
10	Өмнөговь	7	11	4	57.1						

### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>31</sup>



### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	1.3
	Үүнээс: Хүнийг алах		2		0.8
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	74	66	-10.8	27.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	2	-33.3	0.8
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	7	-46.2	2.9
	Үүнээс: Хүчиндэх	12	6	-50.0	2.5
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	3	1	-66.7	0.4
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	62	121	95.2	50.6
	Хулгайлах	29	39	34.5	16.3
	Дээрэмдэх	2			
	Залилах	6	19	3.2 дах	7.9
	Мал хулгайлах	22	48	2.2 дах	20.1
6	Эдийн засгийн гэмт хэрэг	3			
7	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	1.3
8	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	5	4	-20.0	1.7
9	Хүрээлэн байгаа орчны эсрэг	12	19	58.3	7.9
10	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	14	14	0.0	5.9
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	14	14	0.0	5.9
11	Цэргийн албаны эсрэг		1		0.4

### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 30 буюу 12.6 хувь нь даваа гарагт, 40 буюу 16.7 хувь нь мягмар гарагт, 39 буюу 16.3 хувь нь лхагва гарагт, 41 буюу 17.2 хувь нь пүрэв гарагт, 27 буюу 11.3 хувь нь баасан гарагт, 36 буюу 15.1 хувь нь бямба гарагт, 26 буюу 10.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 54 буюу 22.6 хувь нь 06:00-14:00 цагт, 76 буюу 31.8 хувь нь 14:00-

<sup>31</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

19:00 цагт, 40 буюу 16.7 хувь нь 19:00-22:00 цагт, 69 буюу 28.9 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 69 буюу 28.9 хувь нь гэр орон сууцанд, 23 буюу 9.6 хувь нь гудамж талбайд, 9 буюу 3.8 хувь нь олон нийтийн газарт, 8 буюу 3.3 хувь нь аж ахуйн нэгжид, 15 буюу 6.3 хувь нь авто замд, 115 буюу 48.1 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 73 буюу 30.5 хувь нь согтуугаар, 7 буюу 2.9 хувь нь хүүхэд оролцож, 19 буюу 7.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 10 буюу 4.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 19 буюу 7.9 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баруунтуруун	2					
2	Бөхмөрөн	1		1		1	
3	Давст		1	2		1	
4	Завхан	1					
5	Зүүнговь	1	1		1		
6	Зүүнхангай	4		2			
7	Малчин	4		1	1	1	
8	Наранбулаг	3		1	2	2	
9	Өлгий	1				1	
10	Өмнөговь	3				1	
11	Өндөрхангай	3					1
12	Сагил	2		1	1	2	
13	Тариалан	1		1			
14	Түргэн	1			1		1
15	Тэс	2	1			3	
16	Улаангом	41	4	9	4	6	
17	Ховд	2				1	1
18	Хяргас						
19	Цагаанхайрхан	1		1			
	<b>Нийт</b>	<b>73</b>	<b>7</b>	<b>19</b>	<b>10</b>	<b>19</b>	<b>3</b>


## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Увс аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 97 буюу 40.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 74.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.1 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 15.3 нэгжээр өндөр байна.

Илрүүлэлтийн хувь /хэргийн ангиллаар/



### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 194 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 97 хэрэг буюу 2.0 дахин, үүнээс 144 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 75 буюу 2.0 дахин өссөн байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 208 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.2 хувиар өссөн.

Холбогдогчдын 18 буюу 8.7 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд, 190 буюу 91.3 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 12.4 хувиар өсч, 7 буюу 3.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 36.4 хувиар буурсан байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 245 иргэн хохирч, үүнээс 10 хүн нас барж, 74 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 48 буюу 24.4 хувь, нас барсан хүн 5 буюу 2.0 дахин тус тус өсч, гэмтсэн хүн 12 буюу 14.0 хувиар буурсан байна.



### 4.2 Учирсан хохирол.




Иргэдэд учирсан 944.6 сая төгрөгийн хохирлын 68.7 хувийг нөхөн төлүүлж, 216.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 500.2 сая төгрөг буюу 2.1 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 334.5 сая төгрөг буюу 2.0 дахин, битүүмжилсэн хөрөнгө 68.3 сая төгрөг буюу 46.1 хувиар тус тус өссөн байна.

## Тав. Зөрчил

Увс аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 19394 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3675 буюу 23.4 хувиар, 19390 зөрчлийг шийдвэрлэсэн нь 3687 буюу 23.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 17659 буюу 91.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 105 буюу 0.5 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 170 буюу 0.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1460 буюу 7.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 18215 иргэн, 24 хуулийн этгээдийг 935800.3 мянган төгрөгөөр торгох, 447 хүнийг баривчлуулах, 704 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 3449 буюу 23.4, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 144 буюу 25.7, баривчлуулсан шийтгэл 76 буюу 20.5 хувиар тус тус өссөн байна.

2021 онд Увс аймагт нийт 371 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 140 буюу 27.4 хувиар бүүрсан байна.

---oooOooo---



### 3.19 ХОВД АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

#### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.



Ховд аймаг дахь цагдаагийн газар нь 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 3516 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 782 буюу 22.2 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2734 буюу 77.8 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 352 буюу 11.1 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 483 буюу 21.5 хувиар тус тус өсч, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 131 буюу 14.3 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 385 буюу 49.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 365 буюу 46.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 10 буюу 1.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 1154 буюу 42.2 хувийг зөрчлийн хэрэг нээж, 1559 буюу 57.0 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 15 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 416 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22 буюу 5.6 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.7 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 398, сард 33, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:




##### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алтай	28	15	-13	-46.3
2	Булган	39	26	-13	-33.3
3	Буянт	17	25	8	47.1
4	Дарви	4	11	7	2.8 дах
5	Дөргөн	7	10	3	42.9
6	Дуут	6	3	-3	-50.0
7	Жаргалант	187	226	39	20.9
8	Зэрэг	9	9	0	0.0
9	Манхан	12	12	0	0.0
10	Мөст	16	9	-7	-43.8
11	Мөнххайрхан	15	4	-11	-73.3
12	Мянгад	10	14	4	40.0
13	Увс	8	10	2	25.0
14	Ховд	17	17	0	0.0
15	Цэцэг	6	7	1	16.7
16	Чандмань	2	9	7	4.5 дах
17	Эрдэнэбүрэн	11	9	-2	-18.2

#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 355 буюу 85.3 хувь нь хөнгөн, 61 буюу 14.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 7.9 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 6.2 хувиар буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>32</sup>




#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	4	4	0.0	1.0
	Үүнээс: Хүнийг алах	3	1	-66.7	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	111	142	27.9	34.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	5	5.0 дах	1.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	12	8	-33.3	1.9
	Үүнээс: Хүчиндэх	6	5	-16.7	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	4	4.0 дах	1.0
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
6	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	186	184	-1.1	44.2
	Хулгайлах	64	63	-1.6	15.1
	Дээрэмдэх	7	7	0.0	1.7
	Залилах	50	67	34.0	16.1
	Мал хулгайлах	28	17	-39.3	4.1
7	Эдийн засгийн гэмт хэрэг	2	4	2.0 дах	1.0
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	9	3.0 дах	2.2
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2			
10	Авлигын эсрэг гэмт хэрэг		2		0.5
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	6	4	-33.3	1.0
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	37	22	-40.5	5.3
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	29	31	6.9	7.5
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	29	31	6.9	7.5
14	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.2

#### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 59 буюу 14.2 хувь нь даваа гарагт, 67 буюу 16.1 хувь нь мягмар гарагт, 69 буюу 16.6 хувь нь лхагва гарагт, 70 буюу 16.8 хувь нь пүрэв гарагт, 54 буюу 13.0 хувь нь баасан гарагт, 49 буюу 11.8 хувь нь бямба гарагт, 48 буюу 11.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 106 буюу 25.5 хувь нь 06:00-14:00 цагт, 135 буюу 32.5 хувь нь 14:00-19:00 цагт, 70 буюу 16.8 хувь нь 19:00-22:00 цагт, 105 буюу 25.2 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

<sup>32</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 129 буюу 31.0 хувь нь гэр орон сууцанд, 42 буюу 10.1 хувь нь гудамж талбайд, 25 буюу 6.0 хувь нь олон нийтийн газарт, 10 буюу 2.4 хувь нь төрийн байгууллагад, 4 буюу 1.0 хувь нь төрийн бус байгууллагад, 14 буюу 3.4 хувь нь аж ахуйн нэгжид, 31 буюу 7.5 хувь нь авто замд, 161 буюу 38.6 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 123 буюу 29.6 хувь нь согтуугаар, 26 буюу 6.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 26 буюу 6.3 хувь нь бүлэглэн, 24 буюу 6.3 хувь нь хүүхэд оролцож, 33 буюу 7.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн үлмаас тус тус үйлдэгдсэн байна.


Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн үлмаас	Бүлэглэн үйлдсэн
1	Алтай	2	1	1	1	6
2	Булган	10		2	1	
3	Буянт	9	1		2	2
4	Дарви	1				
5	Дөргөн	2			1	
6	Дуут				1	1
7	Жаргалант	74	22	14	25	11
8	Зэрэг	2				
9	Манхан	2			1	
10	Мөст	4		1		
11	Мөнххайрхан	2				
12	Мянгад	3		2		1
13	Үенч	3		2		1
14	Ховд	3		2		2
15	Цэцэг	4		2	1	
16	Чандмань					1
17	Эрдэнэбүрэн	2				1
<b>Нийт</b>		<b>123</b>	<b>24</b>	<b>26</b>	<b>33</b>	<b>26</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Ховд аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 153 буюу 36.8 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 50.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.3 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 8.5 нэгжээр бага байна.



## 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 226 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 44 хэрэг буюу 24.2 хувиар өсч, үүнээс 114 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 2 буюу 1.7 хувиар буурсан байна.


### Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

#### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 346 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.6 хувиар буурсан.

Холбогдогчдын 322 буюу 93.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар буурч, 24 буюу 6.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 4.3 хувиар, 27 буюу 7.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 3.8 хувиар тус тус өссөн байна.


#### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




### Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 403 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, үүнээс 16 хүн нас барж, 162 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 4 буюу 1.0 хувиар буурч, нас барсан хүн 2 буюу 14.3 хувиар, гэмтсэн хүн 22 буюу 15.7 хувиар тус тус өссөн байна.



#### 4.2 Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 862.6 сая төгрөгийн хохирлын 57.0 хувийг нөхөн төлүүлж, 45.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 74.0 сая төгрөг буюу 7.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 48.2 сая төгрөг буюу 8.9 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 203.2 сая буюу 81.7 хувиар тус тус буурсан байна.

### Тав. Зөрчил

Ховд аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 20817 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1450 буюу 7.5 хувиар, 20769 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1426 буюу 7.4 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 19592 буюу 94.1 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 101 буюу 0.5 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 100 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1024 буюу 4.9 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 19499 иргэн, 9 хуулийн этгээдийг 1058836.3 мянган төгрөгөөр торгох, 364 хүнийг баривчлуулах, 897 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 1284 буюу 7.0 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 212 буюу 30.9 хувиар тус тус өсч, торгосон хуулийн этгээд 10 буюу 52.6 хувиар, баривчлуулсан шийтгэл 60 буюу 14.2 хувиар тус тус буурсан байна.

2021 онд Ховд аймагт нийт 1416 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 224 буюу 13.7 хувиар буурсан байна.

---oooOooo---

### 3.20 ХӨВСГӨЛ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

#### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 4294 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1302 буюу 30.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2992 буюу 69.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 332 буюу 8.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 364 буюу 38.8 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 32 буюу 1.1 хувиар буурсан.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 674 буюу 51.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 566 буюу 43.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 8 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2477 буюу 82.8 хувийг зөрчлийн хэрэг нээж, 477 буюу 15.9 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 13 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.


##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 716 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 181 буюу 33.8 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 8.1 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 678, сард 56, хоногт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



##### 1.3 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.




Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алаг-Эрдэнэ	39	261	222	6.6 дах
2	Арбулаг	12	15	3	25,0
3	Баянзүрх	13	7	-6	-46.2
4	Бүрэнтогтох	20	19	-1	-5.0
5	Галт	8	11	3	37.5
6	Жаргалант	15	1	-14	-93.3
7	Их-Уул	14	75	61	5.3 дах
8	Мөрөн	216	170	-46	-21.3
9	Рашаант	4	8	4	2 дах
10	Рэнчинлхүмбэ	15	11	-4	-26.7
11	Тариалан	38	30	-8	-21.1
12	Тосонцэнгэл	22	22	0	0.0
13	Төмөрбулаг	16	16	0	0.0
14	Түнэл	33	9	-24	-72.7
15	Улаан-Уул	16	14	-2	-12.5
16	Ханх	6	2	-4	-66.7
17	Цагаан-Уул	16	12	-4	-25.0
18	Цагааннуур	4	2	-2	-50.0
19	Цагаан-Үүр	3	4	1	33.3
20	Цэцэрлэг	4	4	0	0.0
21	ЧандманьӨндөр	4	8	4	2 дах
22	Шинэ-Идэр	7	10	3	42.9
23	Эрдэнэбулган	10	5	-5	-50.0

#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 622 буюу 86.9 хувь нь хөнгөн, 94 буюу 13.1 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 45.7 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 12.9 хувиар буурсан байна.

#### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>33</sup>




#### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10	10	0.0	1.4
	Үүнээс: Хүнийг алах	5	5	0.0	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	183	181	-1.1	25.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	4	2	-50.0	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	15	14	-6.7	2.0
	Үүнээс: Хүчиндэх	13	13	0.0	1.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	8	7	-12.5	1.0
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	219	414	89.0	57.8
7	Хулгайлах	100	67	-33.0	9.4
	Дээрэмдэх	8	4	-50.0	0.6
	Залилах	26	273	10.5 дах	38.1
	Мал хулгайлах	74	45	-39.2	6.3
8	Эдийн засгийн гэмт хэрэг	1	3	3.0 дах	0.4
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	1	12	12.0 дах	1.7
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.3
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	1			
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	6	6	0.0	0.8
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	57	40	-29.8	5.6
14	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	1			
15	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			
16	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	28	26	-7.1	3.6
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	28	26	-7.1	3.6
17	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1			

#### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 114 буюу 16.0 хувь нь даваа гарагт, 107 буюу 14.9 хувь нь мягмар гарагт, 120 буюу 16.8 хувь нь лхагва гарагт, 102 буюу 14.2 хувь нь пүрэв гарагт, 98 буюу 13.7 хувь нь баасан гарагт, 78 буюу 10.9 хувь нь бямба гарагт, 97 буюу 13.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 181 буюу 25.3 хувь нь 06:00-14:00 цагт, 254 буюу 35.5 хувь нь 14:00-19:00 цагт, 94 буюу 13.1 хувь нь 19:00-22:00 цагт, 187 буюу 26.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

<sup>33</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.



### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 295 буюу 41.2 хувь нь гэр орон сууцанд, 77 буюу 10.8 хувь нь гудамж талбайд, 14 буюу 2.0 хувь нь олон нийтийн газарт, 6 буюу 0.8 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 0.3 хувь нь төрийн бус байгууллагад, 11 буюу 1.5 хувь нь аж ахуйн нэгжид, 26 буюу 3.6 хувь нь авто замд, 285 буюу 39.8 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 185 буюу 25.8 хувь нь согтуугаар, 56 буюу 7.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 23 буюу 3.2 хувь нь бүлэглэн, 20 буюу 2.8 хувь нь хүүхэд оролцож, 34 буюу 4.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн үлмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн үлмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Алаг-Эрдэнэ	9		4		3	
2	Арбулаг	3		5			
3	Баянзүрх	4		1	1		
4	Бүрэнтогтох	4	1	1	3	1	1
5	Галт	2	1		1		
6	Жаргалант	2					
7	Их уул	6			1	1	
8	Мөрөн	101	8	38	15	12	
9	Рашаант	5			2		
10	Рэнчинлхүмбэ	3		1			1
11	Тариалан	7	8	2			
12	Тосонцэнгэл	11	1	2	3		
13	Төмөрбулаг	4		1	2	1	
14	Түнэл	4		2	2	1	
15	Улаан-Уул	3		1		1	
16	Ханх	2			1		
17	Цагаан-Уул	5	1		1		
18	Цагааннуур	1				1	1
19	Цагаан-Үүр						
20	Цэцэрлэг	2			1		
21	Чандмань-Өндөр	2				1	1
22	Шинэ-Идэр	3				1	
23	Эрдэнэбулган	2		1	1		
	<b>Нийт</b>	<b>185</b>	<b>20</b>	<b>56</b>	<b>34</b>	<b>23</b>	<b>4</b>




## Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хөвсгөл аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 444 буюу 62.0 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 65.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.5 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 6.3 нэгжээр их байна.



### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 256 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 133 хэрэг буюу 34.2 хувиар, үүнээс 167 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 77 буюу 31.6 хувиар тус тус буурсан байна.

## Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 665 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44.6 хувиар өссөн.

Холбогдогчдын 54 буюу 8.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 92.9 хувиар, 25 буюу 3.8 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 4.2, 611 буюу 91.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 41.4 хувиар тус тус өссөн байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 4.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 725 иргэн хохирч, үүнээс 22 хүн нас барж, 224 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 169 буюу 30.4, нас барсан хүн 1 буюу 4.8 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 1 буюу 0.4 хувиар буурсан байна.



### 4.2 Учирсан хохирол.




Иргэдэд учирсан 1607.8 сая төгрөгийн хохирлын 60.9 хувийг нөхөн төлүүлж, 35.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 550.7 сая төгрөг буюу 25.5, битүүмжилсэн хөрөнгө 261.0 сая төгрөг буюу 88.1 хувиар тус тус буурч, нөхөн төлүүлсэн хохирол 263.3 сая төгрөг буюу 36.7 хувиар өссөн байна.

## Тав. Зөрчил

Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 24518 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1366 буюу 5.9 хувиар, 24412 зөрчлийг шийдвэрлэсэн нь 1333 буюу 5.8 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 21497 буюу 87.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 388 буюу 1.6 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 266 буюу 1.1 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2 буюу 0.02 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 2365 буюу 9.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 23129 иргэнийг 1190241.0 мянган төгрөгөөр торгох, 445 хүнийг баривчлуулах, 838 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 1028 буюу 4.7 хувиар, баривчлуулсан шийтгэл 63 буюу 16.5 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 244 буюу 41.1 хувиар тус тус өссөн байна.

2021 онд Хөвсгөл аймагт нийт 376 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1038 буюу 73.4 хувиар буурсан байна.

---oooOooo---

## 4.21 ХЭНТИЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Хэнтий аймаг дахь цагдаагийн газар 2021 онд иргэн, хуулийн этгээдээс 4290 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1356 буюу 31.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2934 буюу 68.4 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 525 буюу 13.9, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 342 буюу 33.7 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 183 буюу 6.7 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 610 буюу 45.0 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 689 буюу 50.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 15 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2137 буюу 72.8 хувийг зөрчлийн хэрэг нээж, 624 буюу 21.3 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 109 буюу 3.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэрэг.


Нийт 540 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 9 буюу 1.7 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.1 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 551, сард 46, 2 хоног тутамд 3 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Тус аймагт сүүлийн 10 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



#### 1.3 Бүртгэгдсэн нийт эмт хэрэг /сумдаар/.


Д/д	Сум	2020 он	2021 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Батноров	36	32	-4	-11.1
2	Бат-ширээт	5	13	8	2.6 дах
3	Баянадарга	7	23	16	3.3 дах
4	Баянмөнх	8	8	0	0.0
5	Баян-Овоо	13	24	11	84.6
6	Баянхутаг	34	31	-3	-8.8
7	Биндэр	19	27	8	42.1
8	Бор-Өндөр	60	64	4	6.7
9	Бэрх хот	4			
10	Галшир	24	17	-7	-29.2
11	Дадал	15	15	0	0.0
12	Дархан	20	11	-9	-45.0
13	Дэлгэрхаан	23	15	-8	-34.8
14	Жаргалтхаан	15	25	10	66.7
15	Мөрөн	27	12	-15	-55.6
16	Норовлин	25	25	0	0.0
17	Өмнөдэлгэр	20	21	1	5.0
18	Хэрлэн	146	165	19	13.0
19	Цэнхэрмандал	30	12	-18	-60.0



#### 1.4 Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 415 буюу 76.9 хувь нь хөнгөн, 125 буюу 23.1 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 4.5 хувиар өсч, хүнд гэмт хэрэг 6.7 хувиар буурсан байна.

### 1.5 Тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, 2021 он.<sup>34</sup>




### 1.6 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	18	17	-5.6	3.1
	Үүнээс: Хүнийг алах	13	7	-46.2	1.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	170	205	20.6	38.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	1	0.0	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	17	14	-17.6	2.6
	Үүнээс: Хүчиндэх	16	14	-12.5	2.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	264	268	1.5	49.6
5	Хулгайлах	87	79	-9.2	14.6
	Дээрэмдэх	3	2	-33.3	0.4
	Залилах	26	48	84.6	8.9
	Мал хулгайлах	124	117	-5.6	21.7
6	Эдийн засгийн гэмт хэрэг		1		0.2
	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг		4		0.7
8	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.4
	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	32	10	-68.8	1.9
10	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	26	18	-30.8	3.3
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	26	18	-30.8	3.3

### 1.7 Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 67 буюу 12.4 хувь нь даваа гарагт, 82 буюу 15.2 хувь нь мягмар гарагт, 81 буюу 15.0 хувь нь лхагва гарагт, 74 буюу 13.7 хувь нь пүрэв гарагт, 81 буюу 15.0 хувь нь баасан гарагт, 66 буюу 12.2 хувь нь бямба гарагт, 89 буюу 16.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 104 буюу 19.3 хувь нь 06:00-14:00 цагт, 128 буюу 23.7 хувь нь 14:00-19:00 цагт, 93 буюу 17.2 хувь нь 19:00-22:00 цагт, 215 буюу 39.8 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.




### 1.8 Гэмт хэрэг үйлдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 197 буюу 36.5 хувь нь гэр орон сууцанд, 31 буюу 5.7 хувь нь гудамж талбайд, 13 буюу 2.4 хувь нь авто замд, 21 буюу 3.9 хувь нь олон

<sup>34</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1.1, 1.4, 1.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр хаагдсан, мөн хуулийн 32.5 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болсон гэмт хэрэг хасагдаагүй болно.

нийтийн газарт, 14 буюу 2.6 хувь нь аж ахуйн нэгжид, 6 буюу 1.1 хувь нь төрийн байгууллагад, 256 буюу 47.4 хувь нь бусад газарт тус тус бүртгэгджээ.



### 1.9 Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 195 буюу 36.1 хувь нь согтуугаар, 42 буюу 7.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 42 буюу 7.8 хувь нь бүлэглэн, 11 буюу 2.0 хувь нь хүүхэд оролцож, 37 буюу 6.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 4 буюу 0.7 хувь нь галт зэвсгээр тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Сум	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр
1	Батноров	5		2	1		6
2	Бат-ширээт	3	1		1		2
3	Баянадарга	14		2	2		2
4	Баянмөнх	16	1	4	1		6
5	Баян-Овоо	13	3	3	1		5
6	Баянхутаг	2					1
7	Биндэр	3		1			
8	Бэрх	1	1				
9	Галшир	2		1	1		
10	Дадал	4		1	1		4
11	Дархан	1					
12	Дэлгэрхаан	1					
13	Жаргалтхаан	4		1	4		1
14	Мөрөн	2			2		
15	Норовлин	5		3	2		2
16	Өмнө-дэлгэр	57	3	10	10		6
17	Хэрлэн	19		3	4		4
18	Цэнхэрмандал	43	2	11	7		3
	<b>Нийт</b>	<b>195</b>	<b>11</b>	<b>42</b>	<b>37</b>	<b>42</b>	<b>4</b>

### Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт

#### 2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хэнтий аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 257 буюу 47.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 57.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.3 нэгжээр буурсан. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.7 нэгжээр бага байна.



#### 2.2 Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 325 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 99 хэрэг буюу 23.3 хувиар, үүнээс 186 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 58 буюу 23.8 хувиар тус тус буурсан байна.

### Гурав. Гэмт хэрэгт холбогдогч

#### 3.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 470 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.9 хувиар өссөн. Холбогдогчдын 40 буюу 8.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 21.2 хувиар, 430 буюу 91.5 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 3.6 хувиар тус тус өсч, 16 буюу 3.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 48.4 хувиар буурсан байна.


### 3.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




### Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 4.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 546 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, үүнээс 28 хүн нас барж, 210 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 20 буюу 3.8 хувиар өсч, нас барсан хүн 1 буюу 3.7, гэмтсэн хүн 15 буюу 7.7 хувиар тус тус өссөн байна.



#### 4.2 Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1573.0 сая төгрөгийн хохирлын 42.2 хувийг нөхөн төлүүлж, 46.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 718.3 сая төгрөг буюу 31.3 хувиар буурч, нөхөн төлүүлсэн хохирол 130.0 сая төгрөг буюу 24.3 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 20.5 сая төгрөг буюу 78.2 хувиар тус тус өссөн байна.

### Тав. Зөрчил

Хэнтий аймаг дахь цагдаагийн газрын хэмжээнд нийт 26380 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7818 буюу 22.9 хувиар, 26136 зөрчлийг шийдвэрлэсэн нь 7877 буюу 23.2 хувиар тус тус буурсан байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 24460 буюу 92.7 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 10 нь олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 201 буюу 0.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1709 буюу 6.5 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 25076 иргэн 3 хуулийн этгээдийг 1015275.0 мянган төгрөгөөр торгох, 410 хүнийг баривчлуулах, 647 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 7910 буюу 24.0 хувиар, баривчлуулсан шийтгэл 126 буюу 23.5 хувиар тус тус буурч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 156 буюу 31.8 хувиар өссөн байна.

2021 онд Хэнтий аймагт нийт 725 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 274 буюу 27.4 хувиар буурсан байна.

## ДӨРӨВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ


### 4.1 ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРЭГ

#### Нэг. Бүртгэгдсэн хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд 194 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 гэмт хэргээр буюу 1.0 хувиар, нийслэлийн хэмжээнд 109 бүртгэгдсэн нь 14 гэмт хэргээр буюу 14.7 хувиар тус тус өсч, орон нутгийн хэмжээнд 85 бүртгэгдсэн нь 12 гэмт хэргээр буюу 12.4 хувиар буурсан байна.

##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээнд	192	194	1.0	0.8	0.8
Нийслэлд	95	109	14.7	0.6	0.7
Орон нутагт	97	85	-12.3	1.2	0.9

##### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 199, сард 17, 2 хоног тутамд 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

##### 1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 27 буюу 13.9 хувь нь даваа гарагт, 24 буюу 12.4 хувь нь мягмар гарагт, 32 буюу 16.5 хувь нь лхагва гарагт, 25 буюу 12.9 хувь нь пүрэв гарагт, 28 буюу 14.4 хувь нь баасан гарагт, 28 буюу 14.4 хувь нь бямба гарагт, 30 буюу 15.5 хувь нь ням гарагт тус тус

бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 32 буюу 16.5 хувь нь 06:00-14:00 цагт, 34 буюу 17.5 хувь нь 14:00-19:00 цагт, 36 буюу 18.6 хувь нь 19:00-22:00 цагт, 92 буюу 47.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 123 буюу 63.4 хувь нь гэр, орон сууцанд, 34 буюу 17.5 хувь нь гудамж талбайд, 4 буюу 2.1 хувь нь олон нийтийн газарт, 4 буюу 2.1 хувь нь аж ахуйн нэгжид, 2 буюу 1.0 хувь нь төрийн байгууллагад, 2 буюу 1.0 хувь нь төрийн бус байгууллагад 2 буюу 1.0 хувь нь авто замд, 23 буюу 11.9 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 146 буюу 75.2 хувь нь согтуугаар, 3 буюу 1.5 хувь нь хүүхэд оролцож, 20 буюу 10.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 5 буюу 2.6 хувь нь бүлэглэн, 18 буюу 9.3 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Он	Согтуугаар		Хүүхэд оролцож		Эмэгтэй хүн оролцож		Бүлэглэн үйлдсэн		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Нийт	141	146	1	3	19	20	10	5	22	18

### 1.7 Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 64 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2 хэрэг буюу 3.0 хувиар, үүнээс 61 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 4 буюу 6.2 хувиар тус тус буурсан.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 95.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 97.1 хувь байгаа нь 2.9 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 93.1 хувь байгаа нь 2.7 нэгжээр тус тус буурсан байна.


## Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 201 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9 буюу 4.3 хувиар буурсан. Холбогдогчдын 22 буюу 10.9 хувь нь эмэгтэй, 179 буюу 89.1 хувь нь эрэгтэй, 3 буюу 1.5 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 5.3 хувиар хувиар буурч, хүүхэд 3.0 дахин, эмэгтэй хүн 4.8 хувиар тус тус өссөн байна.




## 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




### Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 3.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 206 иргэн хохирч, үүнээс 171 хүн нас барж, 29 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 10 буюу 5.1 хувиар, гэмтсэн хүн 5 буюу 20.8 хувиар тус тус өсч, нас барсан хүн 19 буюу 10.0 хувиар буурсан байна.



#### 3.2 Учирсан хохирол.



Иргэдэд учирсан 1042.8 сая төгрөгийн хохирлын 88.2 хувийг нөхөн төлүүлж, 46.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 244.5 сая төгрөг буюу 30.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 232.4 сая буюу 33.8 хувиар өсч, битүүмжилсэн хөрөнгө 112.4 сая төгрөг буюу 70.9 хувиар буурсан байна.

---oooOooo---

## 4.2 ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

### Нэг. Бүртгэгдсэн хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ бүлгийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд 7637 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 232 гэмт хэргээр буюу 3,1 хувиар, орон нутгийн хэмжээнд 3085 бүртгэгдсэн нь 247 хэргээр буюу 8.7 хувиар тус тус өсч нийслэлийн хэмжээнд 4551 бүртгэгдсэн нь 13 гэмт хэргээр буюу 0.3 хувиар буурсан байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээнд	7405	7637	3.1	32.1	30.0
Нийслэлд	4564	4551	-0.3	31.2	27.5
Орон нутагт	2838	3085	8.7	33.7	34.7
Бусад	3	1	-66.7	27.3	6.7

#### 1.6 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 7981, сард 665, хоногт 22, цагт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

#### 1.4 Гэмт хэргийн төрөл /Эрүүгийн хуулийн зүйл ангиар/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	2020 он	2021 он	Өсөлт, бууралт		Тухайн хэрэгт эзлэх хувь
				Тоо	Хувь	
1	11.1 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	301	370	69	22.9	4.8
2	11.2 дугаар зүйл.Санаа сэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах	1	2	1	2.0 дах	0.2
3	11.3 дугаар зүйл.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах	40	40	0	0.0	0.5
4	11.4 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	523	607	84	16.1	7.9
5	11.5 дугаар зүйл.Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	56	47	-9	-16.1	0.6
6	11.6 дугаар зүйл.Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	6373	6453	80	1.3	84.5
7	11.7 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	111	118	7	6.3	1.5


#### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1067 буюу 14.0 хувь нь даваа гарагт, 1084 буюу 14.2 хувь нь мягмар гарагт, 1079 буюу 14.1 хувь нь лхагва гарагт, 1079 буюу 14.1 хувь нь пүрэв гарагт, 1170 буюу 15.3 хувь нь баасан гарагт, 1056 буюу 13.8 хувь нь бямба гарагт, 1102 буюу 14.4 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1432 буюу 18.8 хувь нь 06:00-14:00 цагт, 1825 буюу 23.9 хувь нь 14:00-19:00 цагт, 1554 буюу 20.3 хувь нь 19:00-22:00 цагт, 2826 буюу 37.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



#### 1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 2022 буюу 26.5 хувь нь гудамж, талбайд, 3878 буюу 50.8 хувь нь гэр орон сууцанд, 519 буюу 6.8 хувь нь олон нийтийн газарт, 7 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 45 буюу 0.6 хувь төрийн байгууллагад, 26 буюу 0.3 хувь нь төрийн бус байгууллагад, 264 буюу 3.5 хувь нь аж ахуй нэгжид, 6 буюу 0.1 хувь нь авто замд, 870 буюу 11.4 хувь нь бусад газарт үйлдэгджээ.



#### 1.7 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3646 буюу 47.7 хувь нь согтуугаар, 230 буюу 3.0 хувь нь хүүхэд оролцож, 775 буюу 10.1 хувь нь эмэгтэй хүн оролцож, 295 буюу 3.9 хувь нь бүлэглэн, 1377 буюу 18.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Он	Согтуугаар		Хүүхэд оролцож		Эмэгтэй хүн оролцож		Бүлэглэн үйлдсэн	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Нийт	3256	3646	232	230	878	775	219	295

## Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 6999 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 219 буюу 3.2 хувиар өссөн.

Холбогдогчдын 764 буюу 10.9 хувь нь эмэгтэй, 6235 буюу 89.1 хувь нь эрэгтэй, 270 буюу 3.9 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 283 буюу 4.7 хувиар, хүүхэд 20 буюу 8.0 хувиар тус тус өсч, эмэгтэй хүн 64 буюу 7.7 хувиар буурсан байна.

### 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол


### 3.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 8072 иргэн хохирч, үүнээс 27 нас барж, 7299 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 274 буюу 3.5, гэмтсэн хүн 97 буюу 1.3 хувиар, нас барсан хүн 8 буюу 42.1 хувиар тус тус өссөн.

Гэмтсэн иргэдийн гэмтлийн зэргээр нь авч үзвэл 6324 буюу 86.6 хувь нь хөнгөн, 615 буюу 8.5 хувь нь хүндэвтэр, 360 буюу 4.9 хувь нь хүнд зэргийн гэмтэл учирсан байна.



### 3.2 Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/

■ 2020 он ■ 2021 он

Хэргийн улмаас Иргэдэд учирсан 8963.1 сая төгрөгийн хохирлын 80.8 хувийг нөхөн төлүүлж, 484.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 1167.8 сая төгрөг буюу 15.0 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 894.8 сая төгрөг буюу 14.1 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 59.9 сая төгрөг буюу 14.1 хувиар тус тус өссөн байна.

## 4.3 ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРЭГ

### Нэг. Бүртгэгдсэн хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 439 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 38 хэргээр буюу 9.5 хувиар, нийслэлийн хэмжээнд 225 бүртгэгдсэн нь 22 хэргээр буюу 10.8 хувиар, орон нутгийн хэмжээнд 214 бүртгэгдсэн нь 17 хэргээр буюу 8.6 хувиар тус тус өссөн байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээнд	401	439	9.5	1.7	1.7
Нийслэлд	203	225	10.8	0.9	.9
Орон нутагт	197	214	8.6	0.9	0.8
Бусад	1			9.1	

#### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 373, сард 31, хоногт 1 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

#### 1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 59 буюу 13.4 хувь нь даваа гарагт, 67 буюу 15.3 хувь нь мягмар гарагт, 67 буюу 15.3 хувь нь лхагва гарагт, 80 буюу 18.2 хувь нь пүрэв гарагт, 56 буюу

12.8 хувь нь баасан гарагт, 56 буюу 12.8 хувь нь бямба гарагт, 54 буюу 12.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 88 буюу 20.0 хувь нь 06:00-14:00 цагт, 95 буюу 21.6 хувь нь 14:00-19:00 цагт, 51 буюу 11.6 хувь нь 19:00-22:00 цагт, 205 буюу 46.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 311 буюу 70.8 хувь нь гэр, орон сууцанд, 33 буюу 7.5 хувь нь гудамж талбайд, 17 буюу 3.9 хувь нь олон нийтийн газарт, 6 буюу 1.4 хувь нь аж ахуйн нэгжид, 1 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэр, төрийн байгууллагад тус тус, 4 буюу 0.9 хувь нь төрийн бус байгууллагад, 66 буюу 15.0 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 1.6 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 130 буюу 29.6 хувь нь согтуугаар, 19 буюу 4.3 хувь нь хүүхэд оролцож, 7 буюу 1.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 110 буюу 25.1 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 21 буюу 34.8 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Он	Согтуугаар		Хүүхэд оролцож		Эмэгтэй хүн оролцож		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас		Бүлэглэн үйлдсэн	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Нийт	124	130	20	19	3	7	53	110	15	21

### 1.7 Гэмт хэргийн илрүүлэлт.

Хэрэг бүртгэлтийн 308 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 19 хэрэг буюу 6.6 хувиар, үүнээс 168 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 5 буюу 3.1 хувиар тус тус өссөн.

Тухайн гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 54.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.9 нэгжээр, нийслэлийн хэмжээнд 48.9 хувь байгаа нь 1.1 нэгжээр, орон нутгийн хэмжээнд 63.6 хувь байгаа нь 0.3 нэгжээр тус тус буурсан байна.

### Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

#### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 335 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41 буюу 13.9 хувиар өссөн. Холбогдогчдын 6 буюу 1.8 хувь нь эмэгтэй, 329 буюу 98.2 хувь нь эрэгтэй, 24 буюу 7.2 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 12.3 хувиар, эмэгтэй хүн 6.0 дахин, хүүхэд 4 буюу 20.0 хувиар тус тус өссөн байна.

## 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 3.1 Хохирсон иргэн.

Гэмт хэргийн улмаас 458 иргэн хохирч, 51 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс хохирсон хүн 52 буюу 12.8 хувиар өсч, гэмтсэн хүн 1 буюу 1.9 хувиар буурсан.

Хохирсон иргэдийн 278 буюу 60.7 хувь нь 17 хүртэлх насны хүүхэд байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгт хохирогч болсон 10 хүний 6 нь хүүхэд байна гэсэн үг юм. Хохирсон хүүхдийг насаар нь авч үзвэл 18 буюу 6.4 хувь нь 7 хүртэлх, 130 буюу 46.8 хувь нь 8-13 насны, 130 буюу 46.8 хувь нь 14-17 насны хүүхэд байна



---oooOooo---


## 4.4 ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ

### Нэг. Бүртгэгдсэн хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд 4579 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 521 гэмт хэргээр буюу 10.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 3283 бүртгэгдсэн нь 198 гэмт хэргээр буюу 5.7 хувиар, орон нутгийн хэмжээнд 1296 бүртгэгдсэн нь 323 гэмт хэргээр буюу 20.0 хувиар тус тус буурсан байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээнд	5100	4579	-10.1	22.1	18.0
Нийслэлд	3481	3283	-5.7	23.8	19.8
Орон нутагт	1619	1296	-20.0	19.2	14.6

#### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 8310, сард 693, хоногт 23, цагт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

#### 1.4 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 685 буюу 15.0 хувь нь даваа гарагт, 667 буюу 14.6 хувь нь мягмар гарагт, 691 буюу 15.1 хувь нь лхагва гарагт, 695 буюу 15.2 хувь нь пүрэв гарагт, 675 буюу 14.7 хувь нь баасан гарагт, 598 буюу 13.1 хувь нь бямба гарагт, 568 буюу 12.4 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1186 буюу 25.9 хувь нь 06:00-14:00 цагт, 1351 буюу 29.5 хувь нь 14:00-19:00 цагт, 570 буюу 12.4 хувь нь 19:00-22:00 цагт, 1472 буюу 32.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.





1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	190	218	14.7	2.2
	Үүнээс: Хүнийг алах	121	123	1.7	1.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3264	3878	18.8	39.0
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	104	105	1.0	1.1
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	334	386	15.6	3.9

Үүнээс: Хүчиндэх	259	311	20.1	3.1	
4 Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	59	76	28.8	0.8	
5 Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг					
6 Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1	3	3.0 дах	0.0	
7 Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	9	16	77.8	0.2	
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	3723	4764	28.0	47.9	
8 Үүнээс	Хулгайлах	2404	1824	-24.1	18.4
	Залилах	1140	2710	2.3 дах	27.3
	Дээрэмдэх	64	51	-20.3	0.5
	Мал хулгайлах	7	5	-28.6	0.1
9 Эдийн засгийн гэмт хэрэг	6	6		0.1	
10 Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	109	469	4.3 дах	4.7	
11 Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	6	8	33.3	0.1	
12 Авлигын эсрэг гэмт хэрэг	1				
13 Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	18	40	2.2 дах	0.4	
14 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	22	10	-54.5	0.1	
15 Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		2		0.0	
16 Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	75	64	-14.7	0.6	


### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 1533 буюу 15.4 хувь нь даваа гарагт, 1543 буюу 15.5 хувь нь мягмар гарагт, 1485 буюу 14.9 хувь нь лхагва гарагт, 1482 буюу 14.9 хувь нь пүрэв гарагт, 1420 буюу 14.3 хувь нь баасан гарагт, 1278 буюу 12.9 хувь нь бямба гарагт, 1199 буюу 12.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2726 буюу 27.4 хувь нь 06:00-14:00 цагт, 2806 буюу 28.2 хувь нь 14:00-19:00 цагт, 1627 буюу 16.4 хувь нь 19:00-22:00 цагт, 2781 буюу 28.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 3328 буюу 33.5 гэр, 3047 буюу 30.7 орон сууц, 2241 буюу 22.5 хувийн байшин, 401 буюу 4.0 нийтийн байр, 285 буюу 2.9 бусад, 213 буюу 2.1 хувь нь зуслангийн байшин, 142 буюу 1.4 хувь нь орц, 95 буюу 1.0 хувь нь гарааж, 61 буюу 0.6 хувь нь амбаар, 82 буюу 0.8 хувь нь подваль, 19 буюу 0.2 хувь нь агуулах, 26 буюу 0.3 хувь нь хаусд тус тус үйлдэгдсэн байна.



### 1.7 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 2662 буюу 26.8 хувь нь согтуугаар, 240 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 1224 буюу 12.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1312 буюу 13.2 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 315 буюу 3.2 хувь нь бүлэглэн үйлдсэн, 3 буюу 0.03 хувь нь галт зэвсгээр үйлдсэн байна.


	Согтуугаар		Хүүхэд оролцож		Эмэгтэй хүн оролцож		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас		Бүлэглэн үйлдсэн		Галт зэвсгээр үйлдсэн	
Он	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
Нийт	2367	2662	263	240	1054	1224	973	1312	312	315	6	3

## Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 7186 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1500 буюу 26.4 хувиар өссөн. Холбогдогчдын 1125 буюу 15.7 хувь нь эмэгтэй, 6061 буюу 84.3 хувь нь эрэгтэй, 292 буюу 4.1 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 28.1 хувиар, эмэгтэй 17.9 хувиар тус тус өсч, хүүхэд 9.0 хувиар бүүрсан байна.


### 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 3.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 9685 иргэн, 1 хуулийн этгээд хохирч үүнээс 213 нас барж, 3782 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 1834 буюу 23.4 хувиар, нас барсан хүн 12 буюу 5.9 хувиар, гэмтсэн хүн 539 буюу 16.6 хувиар тус тус өссөн байна.



### 3.2 Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 37376.5 сая төгрөгийн хохирлын 52.0 хувийг нөхөн төлүүлж, 1982.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 18477.8 сая төгрөг буюу 97.7 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 10507.9 сая төгрөг буюу 2.1 дахин, битүүмжилсэн хөрөнгө 1194.3 сая төгрөг буюу 2.5 дахин тус тус өссөн байна.

---0000000---

## 5.4 ОЛОН НИЙТИЙН ГАЗАРТ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

### Нэг. Бүртгэгдсэн хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Энэ төрлийн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 124 хэргээр буюу 5.8 хувиар, нийслэлийн хэмжээнд 1632 бүртгэгдсэн нь 136 хэргээр буюу 7.7 хувиар тус тус буурч, орон нутгийн хэмжээнд 389 бүртгэгдсэн нь 16 хэргээр буюу 4.3 хувиар өссөн байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээнд	2145	2021	-5.8	9.3	7.9
Нийслэлд	1768	1632	-7.7	12.1	9.9
Орон нутагт	373	389	4.3	4.4	4.4
Бусад	4			36.4	

#### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 3505, сард 292, хоногт 10 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.


#### 1.4 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	8	13	62.5	0.6
	Үүнээс: Хүнийг алах	6	4	-33.3	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	842	519	-38.4	25.7
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх		1		0.0

3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	28	22	-21.4	1.1
	Үүнээс: Хүчиндэх	22	17	-22.7	0.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	10	7	-30.0	0.3
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1			
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1			
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	1			
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1192	1412	18.5	69.9
8	Үүнээс Хулгайлах	612	675	10.3	14.
	Залилах	410	508	23.9	7.7
	Дээрэмдэх	26	23	-11.5	6.3
	Мал хулгайлах	2			
9	Эдийн засгийн гэмт хэрэг	3	6	2.0 дах	0.3
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	33	25	-24.2	1.2
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	1	-50.0	0.0
12	Авлигын эсрэг гэмт хэрэг	1			
13	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	15	8	-46.7	0.4
14	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	5	7	40.0	0.3
15	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	1	-66.7	0.0


### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 291 буюу 14.4 хувь нь даваа гарагт, 298 буюу 14.7 хувь нь мягмар гарагт, 274 буюу 13.6 хувь нь лхагва гарагт, 305 буюу 15.1 хувь нь пүрэв гарагт, 299 буюу 14.8 хувь нь баасан гарагт, 275 буюу 13.6 хувь нь бямба гарагт, 279 буюу 13.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 604 буюу 29.9 хувь нь 06:00-14:00 цагт, 705 буюу 34.9 хувь нь 14:00-19:00 цагт, 227 буюу 11.2 хувь нь 19:00-22:00 цагт, 485 буюу 24.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 390 буюу 19.3 дэлгүүр, 252 буюу 12.5 зочид буудалд, 144 буюу 7.1 баар, 205 буюу 10.1 нийтийн зах, 179 буюу 8.9 бөөний худалдааны төв, 92 буюу 4.6 зоогийн газар, 58 буюу 2.9 амралтын газар, 59 буюу 2.9 цайны газар, 29 буюу 1.4 түц, 9 буюу 0.4 барьцаалан зээлдүүлэх газар, 31 буюу 1.5 авто вокзал, 7 буюу 0.3 үзвэрийн газар, 5 буюу 0.2 саун, 3 буюу 0.1 жуулчны бааз, 1 буюу 0.04 сувиллын газар, 2 буюу 0.1 төмөр замын вокзал, 9 буюу 0.4 РС тоглоомын газар, нисэх онгоцны буудал, автомат тоглоомын газар, илгээмжийн үйлчилгээний газарт тус бүр 1, 543 буюу 26.8 бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.7 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 316 буюу 15.6 хувь нь согтуугаар, 77 буюу 3.8 хувь нь хүүхэд оролцож, 370 буюу 18.3 хувь нь эмэгтэй хүн оролцож, 23 буюу 1.1 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 123 буюу 6.1 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.

Он	Согтуугаар		Хүүхэд оролцож		Эмэгтэй хүн оролцож		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас		Бүлэглэн үйлдсэн	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
<b>Нийт</b>	490	316	115	77	425	370	18	23	131	123




## Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 1344 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 211 буюу 13.6 хувиар буурсан. Холбогдогчдын 340 буюу 25.3 хувь нь эмэгтэй, 1004 буюу 74.7 хувь нь эрэгтэй, 109 буюу 8.1 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 15.9, хүүхэд 24.8, эмэгтэй хүн 5.5 хувиар тус тус буурсан байна.


### 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




## Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 3.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 2044 иргэн, 4 хуулийн этгээд хохирч үүнээс 13 нас барж, 525 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 118 буюу 5.5 хувиар, гэмтсэн хүн 290 буюу 35.6 хувиар тус тус буурч, нас барсан хүн 2 буюу 18.2 хувиар өссөн байна.



### 3.2 Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 17284.3 сая төгрөгийн хохирлын 62.9 хувийг нөхөн төлүүлж, 556.3 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 14490.6 сая төгрөг буюу 45.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 16394.5 сая төгрөг буюу 60.1 хувиар тус тус буурч, битүүмжилсэн хөрөнгө 368.2 сая төгрөг буюу 2.9 дахин өссөн байна.

---0000000---


## 5.5 ГУДАМЖ ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

### Нэг. Бүртгэгдсэн хэрэг


#### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд 4757 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 293 хэргээр буюу 6.6 хувиар, нийслэлийн хэмжээнд 3796 бүртгэгдсэн нь 288 хэргээр буюу 8.2 хувиар, орон нутгийн хэмжээнд 961 бүртгэгдсэн нь 5 хэргээр буюу 0.5 хувиар тус тус өссөн байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



#### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 5493, сард 457, хоногт 15 хэрэг үйлдэгдсэн байна.


#### 1.4 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Тухайн гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	52	75	44.2	1.6
	Үүнээс: Хүнийг алах	26	34	30.8	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2034	2022	-0.6	42.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	3	3		0.1

3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	43	41	-4.7	0.8
	Үүнээс: Хүчиндэх	36	33	-8.3	0.7
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	10	17	70.0	0.4
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	3	3	0.0	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2145	2427	13.1	51.0
6	Үүнээс				
	Хулгайлах	918	958	4.4	20.9
	Залилах	658	805	22.3	16.9
	Дээрэмдэх	243	247	1.6	5.2
7	Мал хулгайлах	10	15	50.0	0.3
	Эдийн засгийн гэмт хэрэг	3	3		0.1
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	85	59	-30.6	1.2
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	4	7	75.0	0.1
10	Авлигын эсрэг гэмт хэрэг		1		0.0
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	65	78	20.0	1.6
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	18	11	-38.9	0.2
13	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	2		0.2
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	1	11	11.0 дах	0.2
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	1	11	11.0 дах	0.2


### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 705 буюу 14.8 хувь нь даваа гарагт, 703 буюу 14.8 хувь нь мягмар гарагт, 715 буюу 15.1 хувь нь лхагва гарагт, 677 буюу 14.2 хувь нь пүрэв гарагт, 730 буюу 15.3 хувь нь баасан гарагт, 626 буюу 13.2 хувь нь бямба гарагт, 601 буюу 12.6 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1174 буюу 24.7 хувь нь 06:00-14:00 цагт, 1307 буюу 27.5 хувь нь 14:00-19:00 цагт, 776 буюу 16.3 хувь нь 19:00-22:00 цагт, 1500 буюу 31.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл 1421 буюу 29.9 гэр хорооллын гудамж, 1223 буюу 25.7 орон сууцны хорооллын гудамж, 95 буюу 1.9 тоглоомын талбайд, 586 буюу 12.3 ил зогсоолд, 22 буюу 0.5 цэцэрлэгт хүрээлэнд, 447 буюу 9.4 автобусны буудалд, 3 буюу 0.1 төмөр замд, 960 буюу 20.2 бусад газарт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.7 Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 996 буюу 20.9 хувь нь согтуугаар, 238 буюу 5.0 хувь нь хүүхэд оролцож, 459 буюу 9.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 98 буюу 2.1 хувь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 351 буюу 7.4 хувь нь бүлэглэн үйлдсэн байна.


Он	Согтуугаар		Хүүхэд оролцож		Эмэгтэй хүн оролцож		Гэр бүлийн хүчирхийллийн улмаас		Бүлэглэн үйлдсэн		Галт зэвсгээр үйлдсэн	
	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021	2020	2021
<b>Нийт</b>	1050	996	229	238	568	459	74	98	295	351	5	

## Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 3512 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 227 буюу 6.9 хувиар өссөн. Холбогдогчдын 427 буюу 12.2 хувь нь эмэгтэй, 3085 буюу 87.8 хувь нь эрэгтэй, 310 буюу 8.8 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 11.7 хувиар, хүүхэд 11.9 хувиар тус тус өсч, эмэгтэй хүн 18.5 хувиар буурсан байна.

### 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.





## Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

### 3.1 Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4864 иргэн, 1 хуулийн этгээд хохирч үүнээс 75 нас барж, 2015 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүн 324 буюу 7.1 хувиар, нас барсан хүн 20 буюу 36.4 хувиар тус тус өсч, гэмтсэн хүн 52 буюу 2.5 хувиар буурсан байна.

### 3.2 Учирсан хохирол.



Хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан 15003.7 сая төгрөгийн хохирлын 54.4 хувийг нөхөн төлүүлж, 805.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 2754.3 сая төгрөг буюу 22.5 хувиар, битүүмжилсэн хөрөнгө 497.1 сая төгрөг буюу 2.6 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 2848.2 сая төгрөг буюу 53.6 хувиар тус тус өссөн байна.

---oooOooo---

## ЗУРГАА. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ


### 6.1 ЭМЭГТЭЙ ХҮН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГ

#### Нэг. Бүртгэгдсэн хэрэг

##### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд эмэгтэй хүнээс үйлдсэн 3218 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 134 хэргээр буюу 4.0 хувиар, нийслэлийн хэмжээнд 2443 бүртгэгдсэн нь 114 хэргээр буюу 4.5 хувиар, орон нутгийн хэмжээнд 773 бүртгэгдсэн нь 21 хэргээр буюу 2.6 хувиар тус тус буурсан.

##### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээ	3352	3218	-4.0	14.5	12.7
Нийслэлд	2557	2443	-4.5	17.5	14.8
Орон нутагт	794	773	-2.6	9.4	8.7
Бусад	1	2	2.0 дах	9.1	13.3

##### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 3229, сард 269, хоногт 9 гэмт хэрэг бүртгэгдсэн.


##### 1.4 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	42	43	2.4	1.3
2	Үүнээс: Хүнийг алах	19	20	5.3	0.6
3	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	863	775	-10.2	24.1

4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	13	12	-7.7	0.4
5	Үүнээс: Хүчиндэх	3	7	2.3 дах	0.2
6	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	40	42	5.0	1.3
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2068	1994	--3.6	62.0
8	Хулгайлах	283	251	-11.3	7.8
	Залилах	1526	1526		47.4
	Дээрэмдэх	13	16	23.1	0.5
	Мал хулгайлах	20	6	-70.0	0.2
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	30	93	3.1 дах	2.9
10	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	145	104	-28.3	3.2
11	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	145	104	-28.3	3.2
12	Бусад	151	155	2.6	4.8


### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 514 буюу 16.0 хувь нь даваа гарагт, 508 буюу 15.8 хувь нь мягмар гарагт, 542 буюу 16.8 хувь нь лхагва гарагт, 430 буюу 13.4 хувь нь пүрэв гарагт, 469 буюу 14.6 хувь нь баасан гарагт, 384 буюу 11.9 хувь нь бямба гарагт, 371 буюу 11.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1148 буюу 35.7 хувь нь 06:00-14:00 цагт, 1153 буюу 35.8 хувь нь 14:00-19:00 цагт, 355 буюу 11.0 хувь нь 19:00-22:00 цагт, 562 буюу 17.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1225 буюу 38.1 хувь нь гэр орон сууцанд, 459 буюу 14.3 хувь нь гудамж талбайд, 370 буюу 11.4 хувь нь олон нийтийн газарт, 5 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 51 буюу 1.5 хувь нь төрийн байгууллагад, 31 буюу 1.0 хувь нь төрийн бус байгууллагад, 385 буюу 12.0 хувь нь аж ахуйн нэгжид, 101 буюу 3.1 хувь нь авто замд, 591 буюу 18.4 хувь нь бусад газарт бүртгэгджээ.




### Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

#### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2927 эмэгтэй хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 буюу 0.7 хувиар өссөн байна. Үүнээс 64 буюу 2.2 хувь нь 14-17 насны хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 41 буюу 39.0 хувиар буурчээ.

## 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.





### Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 3.1 Хохирсон иргэн.

11275 хүн хохирч, үүнээс 176 хүн нас барж, 3070 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 6 буюу 3.5 хувиар өсч, гэмтсэн хүн 57 буюу 1.8 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 68802.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 77707.5 сая төгрөг буюу 53.0 хувиар буурсан байна.



---0000000---

## 6.2 НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮМҮҮСЭЭС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

### Нэг. Бүртгэгдсэн хэрэг

#### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.


Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн 733 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 78 хэргээр буюу 9.6 хувиар, нийслэлийн хэмжээнд 490 бүртгэгдсэн нь 68 хэргээр буюу 12.2 хувиар, орон нутгийн хэмжээнд 243 бүртгэгдсэн нь 10 хэргээр буюу 4.0 хувиар тус тус буурсан.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.



	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээ	811	733	-9.6	3.5	2.9
Нийслэлд	558	490	-12.2	3.8	3.0
Орон нутагт	253	243	-4.0	3.0	2.7

#### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.



Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 956, сард 80, хоногт 3 гэмт хэрэг бүртгэгдсэн.

#### 1.4 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	4	33.3	0.5
2	Үүнээс: Хүнийг алах	1	3	3.0 дах	0.4
3	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	224	230	2.7	31.4



4	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	25	22	-12.0	3.0	
5	Үүнээс: Хүчиндэх	20	19	-5.0	2.6	
6	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг		3		0.4	
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	510	435	-14.7	59.3	
8	Үүнээс	Хулгайлах	355	257	-27.6	35.1
		Залилах	69	117	69.6	16.0
		Дээрэмдэх	43	21	-51.2	2.9
		Мал хулгайлах	10	12	20.0	1.6
9	Эдийн засгийн гэмт хэрэг	1				
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1	
11	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.1	
12	Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	29	10	-65.5	1.4	
13	Нийтийн албаны ашиг сонихрлын эсрэг гэмт хэрэг		1		0.1	
14	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	9	9	0.0	1.2	
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	9	17	88.9	2.3	
16	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	9	17	88.9	2.3	


### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 119 буюу 16.2 хувь нь даваа гарагт, 129 буюу 17.6 хувь нь мягмар гарагт, 105 буюу 14.3 хувь нь лхагва гарагт, 101 буюу 13.8 хувь нь пүрэв гарагт, 110 буюу 15.0 хувь нь баасан гарагт, 80 буюу 11.0 хувь нь бямба гарагт, 89 буюу 12.1 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 177 буюу 24.1 хувь нь 06:00-14:00 цагт, 223 буюу 30.4 хувь нь 14:00-19:00 цагт, 111 буюу 15.1 хувь нь 19:00-22:00 цагт, 222 буюу 30.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна



### 1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 240 буюу 32.7 хувь нь гэр, орон сууцанд, 238 буюу 32.5 хувь нь гудамж талбайд, 77 буюу 10.5 хувь нь олон нийтийн газарт, 34 буюу 4.6 хувь нь аж ахуйн нэгжид, 1 буюу 0.1 хувь нь төрийн байгууллагад, 143 буюу 19.6 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.



### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 921 хүүхэд холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 69 буюу 7.0 хувиар буурсан байна. Холбогдогчдын 64 буюу 7.0 хувь нь эмэгтэй, 857 буюу 93.0 хувь нь эрэгтэй хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эмэгтэй хүүхэд 39.0 хувиар, эрэгтэй хүүхэд 3.1 хувиар тус тус буурсан байна.


## 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, боловсролын түвшин.




### Гурав. Гэмт хэргийн улмаас хохирсон насанд хүрээгүй хүн

#### 3.1. Хохирсон хүүхэд.

Гэмт хэргийн улмаас 1365 хүүхэд хохирч, үүнээс 83 хүүхэд нас барж, 550 хүүхэд гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүүхэд 184 буюу 15.6 хувиар, гэмтсэн хүн 34 буюу 6.6 хувиар тус тус өсч, нас барсан хүүхэд 16 буюу 16.2 хувиар буурсан байна.



#### 3.2. Учирсан хохирол.



Гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хүнд 2489.2 сая төгрөгийн хохирол учирсан байна.

---oooOooo---

## 6.3 ГАДААДЫН ИРГЭНЭЭС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

### Нэг. Бүртгэгдсэн хэрэг


#### 1.1 Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд гадаадын иргэнээс үйлдсэн 19 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 17 хэргээр буюу 47.2 хувиар, нийслэлийн хэмжээнд 15 бүртгэгдсэн нь 12 хэргээр буюу 44.4 хувиар, орон нутгийн хэмжээнд 4 бүртгэгдсэн нь 5 хэргээр буюу 55.6 хувиар тус тус буурсан. Бүртгэгдсэн хэргийн 12 буюу 33.3 хувь нь хүнд, 24 буюу 66.7 хувь нь хөнгөн гэмт хэрэг эзэлж байна.

#### 1.2 Бүртгэгдсэн гэмт хэргийн гаралт, нутаг дэвсгэрээр.

	Хэргийн тоо		Өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь	
	2020 он	2021 он		2020 он	2021 он
Улсын хэмжээ	36	19	-47.2	0.2	0.1
Нийслэлд	27	15	-44.4	0.2	0.1
Орон нутагт	9	4	-55.6	0.1	0.0

#### 1.3 Гэмт хэргийн түвшин /2012-2021 он/.




Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 84, сард 7 гэмт хэрэг бүртгэгдсэн.

#### 1.4 Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2020 он	2021 он		
1	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	11	12	9.1	63.2
2	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	14	5	-64.3	26.3
3	Хулгайлах	1	2	2.0 дах	10.5
	Залилах	11	3	-72.7	15.7
	Дээрэмдэх	1			
4	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2			
5	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	2			
6	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг		1		5.3
7	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	2	1	-50.0	5.3
8	Бусад	7	1	-85.7	5.3


#### 1.5 Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гараг.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 3 буюу 15.8 хувь нь даваа гарагт, 1 буюу 5.3 хувь нь мягмар гарагт, 1 буюу 5.3 хувь нь лхагва гарагт, 5 буюу 26.3 хувь нь пүрэв гарагт, 4 буюу 21.1 хувь нь баасан гарагт, 3 буюу 15.8 хувь нь бямба гарагт, 2 буюу 10.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 6 буюу 31.6 хувь нь 06:00-14:00 цагт, 6 буюу 31.6 хувь нь 14:00-19:00 цагт, 3 буюу 15.8 хувь нь 19:00-22:00 цагт, 4 буюу 21.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



### 1.6 Гэмт хэрэг үйлдэгдсэн газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 9 буюу 47.4 хувь нь гэр орон сууцанд, 2 буюу 10.5 хувь нь гудамж талбайд, 3 буюу 15.8 хувь нь олон нийтийн газарт, 2 буюу 10.5 хувь нь нийтийн тээвэрт, 3 буюу 15.8 хувь нь аж ахуйн нэгжид бүртгэгджээ.




### Хоёр. Гэмт хэрэгт холбогдогчид

#### 2.1 Гэмт хэрэгт холбогдсон гадаадын иргэн.






Нийт 19 гадаадын иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 буюу 9.5 хувиар буурсан байна.

#### 2.2 Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



#### 2.3 Гадаадын иргэдийн харьяалал.



Улс	11.1 Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	11.5 Хүний эрүүл мэндэд хүндэтгэр хохирол болгоомжгүйгээр учруулах	11.6 Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	17.1 Хулгайлах	17.3 Залилах	21.1 Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах	24.3 Химийн хорт, аюулгүй бодийг хууль бус эргэлтэд оруулах
БНХАУ		1	7	1	1	1	

КАЗАХСТАН		1	1	1	1
ВЬЕТНАМ					
ОХУ					
ИТАЛИ					
АНУ					

### Гурав. Гэмт хэргийн хохирогч, хохирол

#### 3.1 Хохирсон гадаадын иргэн.

Гэмт хэргийн улмаас 42 гадаадын иргэн хохирч, үүнээс 14 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон иргэн 11 буюу 20.8 хувиар буурч, гэмтсэн иргэн 3 буюу 27.3 хувиар өссөн байна.



Гадаадын иргэдэд 3019.2 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 573.7 сая төгрөг буюу 23.5 хувиар өссөн байна.

#### Дөрөв. Зөрчилд холбогдон шалгагдсан болон өртсөн гадаадын иргэд

Зөрчлийн улмаас гадаадын 56 иргэн хохирсоны дотор БНХАУ-ын 30, БНСУ-ын 8, ОХУ-ын 5, АНУ, Беларусь, Туркместан Улсын тус тус 2, Казахстан, Франц, Норвеги, Япон, Турк, Вьетнам, Шри Ланк Улсын тус тус 1 иргэн байна.

Зөрчилд гадаад улсын 3307 иргэн холбогдон шалгагдсан бөгөөд 3263 /98.7%/ иргэнийг торгож, 160 Иргэдэд зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж, 11 /0.3%/ иргэнийг баривчилж, 33 /0.9%/ иргэнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулжээ.

Торгох шийтгэл ногдуулсан 3263 иргэнийг ердийн зөрчилд, 160 Иргэдэд зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж торгуулийн арга хэмжээ авсан байна. Нийт зөрчлийн 2649 буюу 80.1 хувь нь Улаанбаатар хотод, 658 буюу 19.9 хувь нь орон нутагт үйлдэгдсэн гэж бүртгэгджээ.

---oooOooo---

## ДОЛОО. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2021 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮГНЭЛТ

### 1. Цар тахалын үед гадаад улс, орнуудад бүртгэгдсэн гэмт хэргийн чиг хандлага.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хубэй мужийн Вухань хотод үл мэдэгдэх уушгины хатгалгаа дэгдэж, тус улс дахь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын суурин төлөөлөгчийн газарт 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр мэдэгдэж, 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Олон улсын эрүүл мэндийн яаралтай тусламжийн байгууллагаас өвчний дэгдэлтийг зарлаж, улмаар мөн оны 03 дугаар сарын 11-ний өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас үг өвчнийг COVID-19 гэж нэрлэн, цар тахал хэмээн зарласан.

Энэхүү цар тахалын улмаас 2020 оны II дугаар хагас жил болон 2021 онд дэлхийн ихэнх улс орнууд иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлсэн бөгөөд 2020 оны 04 дүгээр сарын эхний долоо хоногт дэлхийн нийт хүн амын хагас буюу 3,9 тэрбум иргэд ямар нэгэн байдлаар хөл хорионд орсон нь хувь хүний нийгмийн харилцаанд оролцох, өдөр тутмын аж төрөх хэв маягт асар ихээр нөлөөлжээ.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албанаас дэлхийн 30 гаруй оронд хийсэн судалгаагаар тодорхой төрлийн гэмт хэрэг ялангуяа хүний амь, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 25, орон байрны хулгай, дээрэмдэх зэрэг гэмт хэрэг 50 орчим хувиар буурсан тухай мэдэгджээ.

Хэдийгээр дээрх төрлийн гэмт хэрэг буурсан боловч зохион байгуулалттай үйлдэгдэж буй гэмт хэргийн үйлдлийн арга улам нарийсаж, цахим сүлжээ /даркнет/ ашиглан мансууруулах бодис наймаалах явдал ихсэж, улмаар 2030 он гэхэд дэлхийн хүн амын 11 хувь нь мансууруулах бодист донтох магадлалтай гэсэн дүгнэлтийг дээрх байгууллагаас гаргасан мэдэгдэлд дурдсан байна<sup>1</sup>. Уг мэдэгдэлд 2010 онд дэлхийн 226 сая хүн мансууруулах бодист донтсон байсан бол 2021 онд энэ тоо 275 сая буюу 22 хувиар өссөн тухай дурджээ.

Үүний шалтгаан нь Ковид-19 цар тахлаас болж ажилгүйдэл ихэссэнтэй холбоотойгоор нэн ядуу иргэдийн тоо нэмэгдсэн, улмаар хөл хорионд байх нь хувь хүнийг сэтгэл зүйн дарамтад оруулж байгаа зэргээс шалтгаалан мансууруулах бодисын хэрэглээ өссөн гэж дүгнэсэн байна.

Нөгөө талаар иргэд гэрээсээ цахим хэлбэрээр гэрээсээ ажиллах, сургалтад хамрагдах болсон нь цахим хэрэглээг огцом нэмэгдүүлж, улмаар даркнет дэх мансууруулах бодисын зах зээл хурдтай тэлснээр жилийн борлуулалт 315 орчим сая америк долларт (264 сая евро) хүрсэн байж болзошгүй тухай дурджээ<sup>35</sup>.

Түүнчлэн FATF буюу Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагаас хийсэн судалгаагаар Ковид-19 цар тахлын үед тухайн улсын Засгийн газраас гаргасан санхүүжилтийг зориулалтын бусаар ашиглах, залилах, кибер гэмт хэргүүд нэмэгдсэн хэмээн үзсэн байна<sup>2</sup>.

Мөн Ковид-19 цар тахалыг таслан зогсоохоор улс орнуудын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь нийгэм эдийн засагт сөргөөр нөлөөлж, гэмт хэргийн зан үйлийг өөрчилж, гэмт хэрэгтнүүд хууль бус үйлдлийн бусад хэлбэрт шилжиж болзошгүй байгааг анхааруулж байна.

Үүнээс гадна Ковид-19 цар тахал нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (AML/CFT) чиглэлээр хяналт, зохицуулалт, бодлогын шинэчлэл хийх, сэжигтэй гүйлгээний тайлан гаргах, олон улсын болон Засгийн газар хоорондын хамтын үйл ажиллагааг нэгтгэхэд сөргөөр нөлөөлж байна гэж тус тус дүгнэснийг бид бүхэн зайлшгүй анхааралдаа авч, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

### 2. Цар тахлын үеийн монгол улсын гэмт хэрэг, зөрчлийн чиг хандлага.

Хурдтай хөгжиж буй өнөөгийн нийгэмд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох, шинжлэх ухааны үндэслэл бүхий суурь судалгаа, түүнд тулгуурлаж иргэдийн эрх зүйн боловсрол, мэдлэгийг

<sup>35</sup> <https://www.dw.com/en/covid-pandemic-fuels-global-drug-use-un-report-finds/a-58026670>

дээшлүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Нөгөө талаар цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалсан нийгэм, эдийн засгийн хүндрэл, цар тахал болон онцгой нөхцөл байдлын үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах ажлыг шинэ шатанд гаргах зүй ёсны зайлшгүй шаардлага бий боллоо.

Криминологийн болон статистикийн судалгаагаар цагдаагийн байгууллагад 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн өсөлт, бууралтад тухайн бүс нутаг, нийгэм, эдийн засаг, цаг үеийн нөхцөл байдал шууд болон шууд бусаар нөлөөлж байна.

Дэлхий нийтийн хэмжээнд тархаад байсан Ковид-19 цар тахлын анхны тохиолдол 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Монгол Улсад анх бүртгэгдсэнээр Засгийн газар, Улсын онцгой комиссоос шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлснээс хойш 2021 онд Улаанбаатар хотод 3 удаа 52 хоногийн хатуу хөл хориог тогтоосон байна<sup>36</sup>.

Тухайлбал,

-“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 01 дүгээр сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийг дуустал;

-“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 02 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар тогтоолоор 02 дугаар сарын 11-ний өдрөөс 23-ны өдрийг дуустал;

-“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 04 дүгээр сарын 08-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд хатуу хөл хорио тогтоох шийдвэрийг тус тус гаргажээ.

Хөл хорионы үеийн тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээллийг хөл хориогүй үеийн тухайн сард бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэлтэй харьцуулахад 2021 оны 01 дүгээр сард улсын хэмжээнд 1789, 02 дугаар сард хамгийн бага буюу 1145, 04 дүгээр сард 1452 гэмт хэрэг бүртгэгдсэн нь тухайн онд хамгийн их бүртгэгдсэн 11 дүгээр сарын гэмт хэргээс 68.0 хувиар бага байна.

Өнгөрсөн 2021 онд цагдаагийн байгууллагад улсын хэмжээнд хэмжээнд нийт 25.429 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 16.534 буюу 65.0 хувь нь Улаанбаатар хотод, 8880 буюу 34.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад улсын хэмжээнд 2365 гэмт хэрэг буюу 10.3 хувиар, нийслэлийн хэмжээнд 1901 хэрэг буюу 13.0 хувиар, орон нутгийн хэмжээнд 460 хэрэг буюу 5.5 хувиар тус тус өссөн тоон мэдээлэл гарч байна.

Харин дээрх хугацаанд цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 2.074.412 зөрчил шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 202.456 буюу 8.9 хувиар, үүнээс 2.069.950 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 202.396 буюу 8.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 1.960.507 иргэн, 60.708 хуулийн этгээдийг 75.0 тэрбум төгрөгөөр торгох, 15.277 хүнийг баривчлах, 33.458 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Мөн хугацаанд улсын хэмжээнд 70.479 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 23.384 буюу 24.9 хувиар буурсан байх бөгөөд үүнээс 55.002 хүн буюу 78.0 хувь нь Улаанбаатар хотод, 15.477 хүн буюу 22.0 хувь нь орон нутагт эрүүлжүүлэгджээ.

2021 онд 16 ба түүнээс дээш насны 10 000 хүн тутамд улсын хэмжээнд 118, нийслэлд 169, орон нутагт 76 гэмт хэрэг ногдож байна. Үүнээс нийслэлийн Сүхбаатар дүүрэгт 234, Чингэлтэй дүүрэгт

<sup>36</sup> <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/COVID-19-AML-CFT.pdf>

184, орон нутагт Говьсүмбэр аймагт 117, Дорноговь аймагт 104 буюу хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа нь гэмт хэргийн гаралтад хүн амын тоо, оршин суугчдын нягтаршил шууд нөлөөлж байна.

Түүнчлэн гэмт хэрэг 9 аймаг, 2 дүүрэгт 1.1 хувиас 39.3 хувиар буурч, 12 аймаг, 7 дүүрэгт 1.7 хувиас 54.1 хувиар өссөн, бүртгэгдсэн гэмт хэргийн 4842 буюу 19.0 хувь нь согтуугаар, 3218 буюу 12.7 хувь нь эмэгтэй хүн, 733 буюу 2.9 хувь нь хүүхэд тус тус оролцсон, 1367 буюу 5.4 хувь нь бүлэглэн, 1531 буюу 6.0 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн тоон үзүүлэлт гарч байна.

Үндэсний статистикийн хорооноос Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вируст (COVID-19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн 8 дахь тандалт судалгааны тайланд 2021 оны 2 дугаар улирлын байдлаар статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа 210.9 мянган хуулийн этгээдийн 93.6 мянга буюу 44.4 хувь нь үйл ажиллагаа явуулж, 117.3 мянга буюу 55.6 хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн 63.1 мянга буюу 53.8 хувь нь үйл ажиллагаа эхлээгүй бол 46.2 хувь нь бусад шалтгаантай байна. Үйл ажиллагаа эхлээгүй хуулийн этгээдийн эзлэх хувь 1.3 хувиар өссөн тухай дурьджээ<sup>37</sup>.

Дээрх тайлангаас харвал үйл ажиллагаа нь эхлээгүй байгаа аж ахуйн нэгжийн тоон үзүүлэлттэй урвуу хамааралтайгаар ажилгүй иргэдийн тоо өсч, ажилгүйчүүдийн түвшин 2019 оноос 3.6 нэгжээр өсжээ.

Гэмт хэрэг, зөрчил нь нийгэм, эрх зүйн үзэгдэл бөгөөд өөрийн зүй тогтолтой, дотоод зөрчилтэй, нийгмийн бусад үзэгдэлтэй шууд хамааралтай байдгаараа их онцлог юм. Өөрөөр хэлбэл нийгэм дэх гэмт явдлын гаралтын төвшинд нөлөө үзүүлж буй нөхцөл, бие хүн болон бүлэг хүмүүсийг гэмт үйл ажиллагаанд татан оруулж буй шалтгааныг судлан тогтоох нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ шатанд, оновчтой зохион байгуулах үндэс болно гэж үзэж байна.

Энэ хүрээнд цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн өсөлт бууралтад шууд болон шууд бусаар нөлөөлж буй нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлж, динамик загварыг боловсруулан, системийн түвшинд тодорхойлох бодлогыг баримталж байна.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийг үйлдэгдсэн гараг, цаг хугацаагаар нь авч үзвэл долоо хоногийн бүх өдөр жигд байгаа нь согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарь урт, сард зөвхөн нэг өдөр хязгаарлалт хийж байгаатай шууд холбоотой гэж үзэхээр байгаа бөгөөд үүнийг системийн динамик судалгаагаар согтууруулах ундаа худалдаалах цэгийг 10 хувиар бууруулахад гэмт хэрэг 8, цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэхэд 12 хувиар тус тус буурах төлөв ажиглагдлаа.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт дурдсанаар манай улсын нийгэм, эдийн засгийн төлөв байдал болон дэд бүтцийн хөгжил дагасан 70 гаруй төв, суурин газрын хүн амын тоо цаашид нэмэгдэх, улмаар зарим суурин газар шинээр бий болох хандлагатай байна.

Энэ нь хотжилт болон цар тахалаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл бэрхшээл, түүнийг дагасан ажилгүйдлээс шууд хамааралтай гэмт хэргийн өсөлтийг дагуулж болзошгүй юм.

Өнгөрсөн 2020 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн статистик судалгааг үндэслэн системийн динамик загвараар тооцоолж ирэх 10 жилийн байдлаар гаргахад 2021 онд Ковид-19 цар тахалын тархалт, хөл хорионы нөхцөл байдлаас шалтгаалж гэмт хэрэг, зөрчил өсөх буюу “U” хэлбэрийн өөрчлөлтийг авчирна гэж тооцоолсон.

#### Бүртгэгдсэн гэмт хэргийн харьцуулалт:

Нутаг дэвсгэр	Гэмт хэргийн 2020 оны статистик тоо мэдээ	Гэмт хэргийн 2021 оны статистик тоо мэдээ	Системийн динамик загвараар 2021 онд бүртгэгдэж болзошгүй гэмт хэргийн тооцоолол	Зөрүү (тоо)
Нийслэл	14633	16534	15432	1102
Орон нутаг	8420	8880	10249	-1369

<sup>37</sup> Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Корона вируст (COVID - 19) халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, хөл хорио тогтоох арга хэмжээний үзүүлсэн нөлөөллийн тандалт 8 дахь судалгааны тайлан 2021 он



Улсын хэмжээнд	23064	25414	25681	-267
----------------	-------	-------	-------	------

Урьдчилсан байдлаар системийн динамик судалгаагаар хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн суурь шалтгаан нь гэмт хэрэг жилд дунджаар 6.0 хувиар, ялангуяа хулгайлах, залилах гэмт хэрэг 8.0, хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулах гэмт хэрэг 10.0, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэрэг 11.0, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13 хувиар тус тус өсөх төлөвтэй байна.

Мөн уг судалгаагаар согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх, цагдаагийн хүн хүчийг нэмэх, шилжин суурьшилтыг хязгаарлах зэрэг зарим төрлийн арга хэмжээ авснаар гэмт хэргийн гаралт богино хугацаандаа буурах боловч, урт хугацаандаа боловсролын байгууллагын төсвийн хувийг нэмэгдүүлж, бүх шатны боловсролын хөтөлбөрийг шинэчлэх, ажлын байрыг нэмэгдүүлж, хот төлөвлөлт, шилжилт хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах зэрэг цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь гэмт хэргийг 20 хүртэл хувиар бууруулах боломжийг бүрдүүлэхээр байна.

Үндэсний статистикийн хорооноос 2021 оны 12 дугаар сард гаргасан судалгаагаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 13.4, өмнөх сараас 2.1 хувиар өссөн дүнтэй гарсан нь цар тахалын үеийн ажилгүйдэл, аж ахуй нэгжийн хэвийн үйл ажиллагааны доголдол, экспорт импортын барааны нийлүүлэлттэй шүүд холбоотой байгаа нь өмчийн эсрэг гэмт хэрэг 13 хувиар, цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг 2.6 дахин өсөх үндсэн шалтгаан болжээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээнд тулгуурлан зөвхөн дээрх шалтгааныг үндэслэн шугаман хамаарлаар тооцон үзвэл ирэх жилүүдэд халаасны хулгай IV, X, XII, орон байрны хулгай IV, VIII, IX, X, малын хулгай IX, X, XI дүгээр саруудад өсөх магадлалтай байна.

Түүнчлэн улирлын чанартай хүний эрх чөлөө, эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг IV, V, хүчиндэх, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг зуны IV-VIII, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг VIII-XI, амиа хорлох тохиолдол III-VII саруудад нэмэгдэх хандлага ажиглагдсан.

Мөн ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэрэг нь иргэдийн анхаарал, болгоомжгүй байдал, гэр бүлийн таагүй уур амьсгал, уур бухимдал, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх зэрэг шалтгаанууд зонхилжээ.

Иймд иргэдэд туслах, тайлбарлах, зөвлөх, шаардлага, мэдэгдэл хүргүүлэн баг, хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, хамтарсан баг, хэсгийн ахлагч, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, малчдын нөхөрлөл зэрэг байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл технологид суурилсан урьдчилан сэргийлэх ажлыг гол чиглэл болгох нь зүйтэй байна.

Мөн хүн ам ихээр суурьшин төвлөрөх сүм, суурин газарт одооноос гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх техник технологи, дэд бүтцийг нэмэгдүүлэх, сайжруулах, цагдаагийн байгууллагын хүний нөөцийг төлөвлөхөөс гадна орон нутгийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд урт хугацаандаа ашигт малтмал дагасан шилжилт хөдөлгөөн, уул уурхайн ажиллах хүчний төвлөрөл шүүд нөлөөлөх хүчин зүйл нэг болно гэдгийг тус тус анхаарах шаардлагатай байна.

## ДҮГНЭЛТ:

Өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн амын талаас илүү хувь нь нийслэл хотод, үлдсэн хувь нь нүүдлийн мал аж ахуй эрхлэн орон нутагт амьдардаг иргэдтэй манай улсын хувьд хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, иргэдэд эрх зүйн боловсролыг хүртээмжтэй, үр дүнтэй олгох, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил нь зөвхөн хууль сахиулах байгууллагын үүрэг гэх өрөөсгөл хандлагыг өөрчлөх, улмаар төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэн бүрийн оролцоонд тулгуурлах цаг нэгэнт болжээ.

Энэ ч утгаараа Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Хүн, нийгмийн амар тайван байдал хэсгийн Зорилт 7.3-д Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх,

таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бүрдүүлэхээр зааж нэгдүгээр үе шат (2021-2030)-ийн хүрээнд дараах зорилтыг тавьсан.

Үүнд:

-Хууль сахиулах болон тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх чадавхыг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн хөгжүүлнэ;

-Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ гэсэн зорилтыг тавьжээ.

Иймд төв, орон нутгийн цагдаагийн байгууллага нь дээрх бодлогын баримт бичиг, бусад суурь судалгааг үндэслэн тухайн нутаг дэвсгэр дээр үйлдэгдэж болзошгүй болон үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг тусгаж, үе шаттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал,

-Хөнгөн болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, агуулах, тээвэр логистик дагасан иргэдийн суурьшлын бүсийн онцлогийг харгалзан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын загварыг тодорхойлж хөршийн холбоо, урамшуулалт эргүүл, ахмадын холбоо, нэгдэл, аюулгүйн орчин (Аюулгүйн баянбүрд)-ыг бий болгох;

-Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх ажлыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай уялдуулах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

-Шилжин ирэгсэд, түр оршин суугч, бүртгэлгүй иргэдэд тавих хяналтыг сайжруулах, холбогдох чиглэлээр эрх бүхий байгууллагад тодорхой санал уламжлан шийдвэрлүүлэх;

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр аж ахуй нэгж, байгууллагатай хамтран ажиллах шинэ арга хэлбэрийг тодорхойлох, тэдгээрийн ажилтан, алба хаагчдад сургалт зохион байгуулах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж бүрдүүлэх, сонирхлоороо нэгдсэн идэвхтэй бүлэг, хамтлаг байгуулах гэх мэт шинэлэг арга хэлбэрийг бий болгох;

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, таслан зогсоох уламжлалт арга барилыг криминологийн болон нийгмийн бусад шинжлэх ухааны суурь судалгаанд үндэслэн, олон нийт болон мэдээлэл технологид суурилсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хослуулах замаар цагдаагийн байгууллагын чадамжийг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА